



## ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот

2020 оны 12 дугаар сарын 25-ны өдөр

Тус байгууллага нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллалаа.

### **Нэг. Салбарын хөгжлийн бодлогын санал боловсруулах, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр:**

Иргэний нисэхийн багц дүрмийн шинэчлэлтэй холбогдуулан эдийн засгийн холбогдолтой дүрэм боловсруулах ажлын хүрээнд агаарын тээврийн эдийн засгийн зохицуулалтад тулгамдаж буй асуудал, ОУИНБ-ын гаргасан баримт бичгийн зөвлөмж, бусад орны холбогдох дүрэм журмын талаар судалж, дүрмүүдийн төслийг шинэчлэн боловсруулж, 2020 оны 6 дугаар сарын 16-ны өдөр ИНЕГ-ын цахим хуудсанд байршуулан, Захиргааны ерөнхий хууль, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны “Нөлөөллийн шинжилгээ хийх аргачлал батлах тухай” А/147 дугаар тушаалаар баталсан аргачлалын дагуу танилцуулга, нөлөөллийн шинжилгээ боловсруулан, Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлд заасны дагуу холбогдох байгууллагуудаас санал авахаар 2020 оны 09 дүгээр сарын 03, 22-ны өдрүүдэд зохион байгуулсан хэлэлцүүлгийн тэмдэглэл, саналыг нэгтгэн боловсруулж, хуулийн дагуу бүрдүүлэх хавсралт материалуудыг бэлдсэн. Үүнд:

- 1.1. Олон улсын шугамыг хуваарилах, агаарын тээвэрлэгчийг томилох дүрмийн төсөл;
- 1.2. Гадаадын агаарын тээвэрлэгчид эдийн засгийн нөхцөл, чадамжийг үнэлэн, зөвшөөрөл олгох дүрмийн төсөл;
- 1.3. Агаарын тээвэрлэгчийн даатгал дүрмийн төсөл;
- 1.4. Иргэний нисэхийн төлбөртэй үйлчилгээний төрөл, үнэ тариф, хураамжид хяналт тавих дүрмийн төсөл;
- 1.5. Статистикийн мэдээлэл дүрмийн төсөл;
- 1.6. Нөхөн олговортой нислэг зохицуулах дүрмийн төсөл;
- 1.7. Аяллын дугаар хамтран ашиглах журмын төсөл.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Төрөөс агаарын тээврийн салбарт баримтлах бодлогод тулгуурлан орон нутгийн болон олон улсын нислэгийн тоог нэмэгдүүлэх, өрсөлдөөнийг дэмжих замаар тус салбарт үнэ тарифыг бууруулах”, Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлогын баримт бичигт “Агаарын тээврийн тээврийн салбарт татварын таатай орчин бүрдүүлэх замаар агаарын тээврийн өрсөлдөх болон санхүүгийн чадавхыг сайжруулах, иргэний нисэхийн үйлчилгээний өсөн нэмэгдэж байгаа эрэлт хэрэгцээг хангахад чиглэсэн санхүүгийн бодлогыг төрөөс баримтална” гэж тусгагдсаны дагуу орон нутгийн хуваарьт нислэгийн үйлчилгээ болон орон нутгийн нисэх буудлын үйлчилгээг НӨАТ-аас чөлөөлөх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх судалгаа, бичиг баримтыг боловсруулан, хуулийн нэмэлт өөрчлөлт оруулах саналыг хавсралтуудын хамт шинэчлэн 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 01/1066 тоот, 2020 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 01/1904 тоот, 2020 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн 01/2341 тоот албан бичгээр тус тус ЗТХЯ-нд хүргүүлсэн.

Иргэний агаарын хөлөг, түүний эд анги, бүрэлдэхүүн хэсгийг гааль, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх хуулийн төслийн үзэл баримтлал, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төсөл, холбогдох судалгаа бүрдүүлбэрийн хамт боловсруулан 2020 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 01/1624 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн.

ИНД-ийн боловсруулалтын хувьд нийт боловсруулах 48 ИНД бүгд англи хэл дээр боловсруулагдсан бөгөөд үүнээс орчуулан нэгтгэж, 35 ИНД-ийг ЗТХЯ-нд холбогдох материалын хамт хүргүүлэн, Зам, тээврийн хөгжлийн Сайдын 2019 оны 06 сарын 12-ны өдрийн 187 дугаар тушаалаар батлуулж, улсын нэгдсэн бүртгэлийн 4414 дугаарт бүртгүүлсэн. Үүнд:

1. ИНД-12 Осол, зөрчил болон статистик мэдээлэл
2. ИНД-21 Бүтээгдэхүүн, эд ангийн гэрчилгээжүүлэлт
3. ИНД-26 Нислэгт тэнцэх чадварын нэмэлт шаардлага
4. ИНД-39 Нислэгт тэнцэх чадварын удирдамж
5. ИНД-43 Техник үйлчилгээний ерөнхий дүрэм
6. ИНД-47 Агаарын хөлгийн бүртгэл
7. ИНД-61 Нисгэгчийн үнэмлэх, зэрэглэл
8. ИНД-63 Нисэх инженерийн үнэмлэх, зэрэглэл
9. ИНД-65 Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ажилтны үнэмлэх, зэрэглэл
10. ИНД-66 Агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтны үнэмлэх
11. ИНД-67 Эрүүл мэндийн стандарт болон гэрчилгээ
12. ИНД-71 Агаарын зайг тогтоох болон ангилах
13. ИНД-77 Нислэг үйлдэх агаарын зайд нөлөөлөх байгууламж



14. ИНД-92 Аюултай бараа тээвэрлэх
15. ИНД-95 Хэрэглэлийн нислэгийн журмын бүртгэл
16. ИНД-101 Хүнгүй агаарын хөлөг, пуужин, жиро-глайдер болон парасэйлийн үйл ажиллагааны дүрэм
17. ИНД-103 Хэт хөнгөн агаарын хөлгийн үйл ажиллагааны дүрэм
18. ИНД-104 Глайдерын үйл ажиллагааны дүрэм
19. ИНД-105 Шүхрийн үйл ажиллагааны дүрэм
20. ИНД-106 Ханг-глайдерын үйл ажиллагааны дүрэм
21. ИНД-108 Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр
22. ИНД-100 Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо
23. ИНД-102 Хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээжүүлэлт
24. ИНД-129 Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлт
25. ИНД-109 Зохицуулалттай агаарын ачааны байгууллагын гэрчилгээжүүлэлт
26. ИНД-140 Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт
27. ИНД-141 Нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээжүүлэлт
28. ИНД-145 Агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт
29. ИНД-146 Агаарын хөлөг зохион бүтээх байгууллагын гэрчилгээжүүлэлт
30. ИНД-147 Нисэхийн техник үйлчилгээний сургалтын байгууллагын гэрчилгээжүүлэлт
31. ИНД-148 Агаарын хөлөг үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээжүүлэлт
32. ИНД-149 Нисэх клубийн гэрчилгээжүүлэлт
33. ИНД-139 Аэродромын үйл ажиллагаа, гэрчилгээжүүлэлт
34. ИНД-157 Аэродром байгуулах, өөрчлөх, нээх ба хаах
35. Иргэний нисэхийн төлбөртэй үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээ, үйлчилгээний орлогыг зарцуулах журам

Үлдсэн 13 ИНД (91, 115, 119, 121, 125, 133, 135, 137, 171, 172, 173, 174, 175)-ийг эцэслэн боловсруулж, мөн Иргэний нисэхийн нэр томъёоны тайлбарыг эцэслэн боловсруулж, 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 01/4534 тоот албан бичгээр, 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 01/4416 тоот албан бичгээр тус тус ЗТХЯ-нд хүргүүлсэн. ЗТХЯ-ны 2020 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 09/171 тоот "ИНД-ийн нэр томъёоны тайлбар Иргэний нисэхийн тухай хууль болон Захиргааны ерөнхий хуулийн 60.1.2-т заасан шаардлагад нийцэхгүй тул буцаах тухай" албан бичигт ИНЕГ-ын даргын 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 01/165 тоот албан бичгээр ИНД-ийн нэр томъёоны тайлбарыг батлах шаардлага, үндэслэлд тайлбар хийн дахин хүргүүлсэн. 13 ИНД-ийг хянан үзэхэд ИНТХ-д заасан *нисэхийн аюулгүй ажиллагаа* болон *нисэхийн аюулгүй байдлын* нэр томъёотой зөрчилдсөн нь Захиргааны ерөнхий хуулийн 60.1.1-д заасан шаардлагыг хангаагүй тул ИНД-ийн утга агуулга, найруулгыг ИНТХ болон Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн боловсруулж ирүүлэх тухай ЗТХЯ-ны 2020 оны 4 дүгээр сарын 23-ны 01/1830 тоот албан бичиг ирүүлсэнтэй холбогдуулан 2020 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн 01/1069 тоот албан бичгээр **"safety", "security"** нэр томъёог ИНД-д зөв болгож хэрэглэсэн талаар иргэний нисэхийн салбарын хүрээнд хийсэн хэлэлцүүлгийн үр дүнг үндэслэн харуу тайлбар хүргүүлсэн. 2020 оны 5 дугаар сарын 23-ны өдөр Хэлний бодлогын зөвлөл, ИНЕГ, агаарын тээвэрлэгчид, агаарын тээвэрлэгчдийн холбоо болон нисгэгчдийн холбоог төлөөлсөн нийт 21 хүн оролцсон **"safety", "security"** нэр томъёог хэрхэн зөв хэрэглэх зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан. Уг уулзалтаар ИНД-д **"safety-аюулгүй байдал", "security-аюулгүйн хамгаалалт"** гэж хэрэглэсэн нь Үндсэн хууль болон бусад хуульд нийцэж байгаа талаарх шийдвэрийг Хэлний бодлогын зөвлөлөөс 2020 оны 6 сарын 17-ны 44 тоот албан бичгээр ирүүлсэн. Хууль, эрх зүй, дүрмийн боловсруулалтын газраас 2020 оны 8 сарын 14-нд Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газартай ИНД-ийн нэр томъёоны талаар уулзалт зохион байгуулж, үлдсэн 13 дүрмийг батлахдаа, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 4414 дугаарт бүртгэгдсэн өмнөх 35 дүрэмд хэрэглэсэн нэр томъёог баримтлах шаардлагатай гэсэн шийдвэрийг гаргасан. 2020 оны 8 дугаар 26-ны 01/2244 тоот 13 ИНД батлуулах тухай албан бичгээр дээрх Хэлний бодлогын үндэсний зөвлөл болон Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын уулзалтын тэмдэглэлийг ЗТХЯ-нд хүргүүлсэн. ЗТХЯ-ны 2020 оны 10 дугаар сарын 12-ны 09/4814 тоот "ИНД-ийн талаар чиглүүлэх хүргүүлэх тухай" албан бичгээр 13 ИНД-ийг хууль тогтоомжид нийцүүлэн өөрчлөх, ИНД-ийн нэр томъёоны тайлбарыг батлах эрх зүйн үндэслэл байхгүй тул MNS6409:2015 ашигла гэж буцаасан. Энэ албан бичгийн дагуу холбогдох тайлбар болон шаардлагатай өөрчлөлт хийж, ИНЕГ-ын Даргын зөвлөлийн хурлаар 2020 оны 12 сарын 16-нд хэлэлцүүлж, ИНЕГ-ын 2020 оны 12 сарын 18-ны өдрийн 01/3157 тоот албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн сайдад батлуулахаар дахин хүргүүлсэн.

1. ИНД-91 Нислэгийн үйл ажиллагааны ерөнхий дүрэм
2. ИНД-115 Чөлөөт нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээжүүлэлт
3. ИНД-119 Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлт
4. ИНД-121 Том нисэх онгоцны арилжааны нислэгийн үйл ажиллагаа
5. ИНД-125 Дунд нисэх онгоцны арилжааны нислэгийн үйл ажиллагаа
6. ИНД-133 Нисдэг тэргээр дүүжин ачаа тээвэрлэх үйл ажиллагаа
7. ИНД-135 Нисдэг тэрэг болон жижиг нисэх онгоцны арилжааны нислэгийн үйл ажиллагаа
8. ИНД-137 Хөдөө аж ахуйн агаарын хөлгийн үйл ажиллагаа
9. ИНД-171 Агаарын навигацийн техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт
10. ИНД-172 Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт
11. ИНД-173 Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт
12. ИНД-174 Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт
13. ИНД-175 Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт



Эрх зүйн баримт бичгийн нэгдсэн цахим сан бүрдүүлэх ажлын хүрээнд ИНЕГ-ын хэмжээнд мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, журам, стандарт, заавруудыг дотооддоо ашиглах нэгдсэн цахим сан бүрдүүлж, харьяа хэлтэс, алба, салбаруудад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эрх зүйн баримт бичгүүдийн жагсаалтыг гарган төрөлжүүлэн ангилсан. Үүнд: 41 хууль /Иргэний нисэхийн хууль болон холбогдох бусад хуулиуд/, 39 дотоодод мөрдөгдөж буй дүрэм /дотоод аудитын дүрэм, нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг, г.м/, 62 ИНБД, 175 журам /албаны журам, харилцан ажиллагааны журам г.м/, 62 заавар, 35 баримт бичиг /Чикагогийн конвенци, Бүс нутгийн нэмэлт зохицуулалтууд, Аюулгүй ажиллагааны удирдамжууд г.м/, дээд газрын тогтоол шийдвэр /УИХ-ын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Сайдын тушаал, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл г.м/-үүдийг байгууллагын цахим хуудсанд төрөлжүүлэн байршуулсан.

ИНЕГ-ын даргын 2020 оны А/270 дугаар тушаалаар "Түр зурвас, талбайг сонгох, бүртгэх журам", А/275 дугаар тушаалаар "Иргэний нисэхийн аюулгүйн үзлэгийг ажилтан болон зааварлагчийг үнэмлэхжүүлэх журам", А/276 дугаар тушаалаар "Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, шалгалтын ерөнхий журам", А/368 дугаар тушаалаар "Иргэний нисэхийн ерөнхий газрын цахим хуудас ажиллуулах журам"-ын баталж, А/300 дугаар тушаалаар "Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагыг нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллээр хангах ерөнхий журам", А/486 дугаар тушаалаар "Түр аэрдром, талбай ашиглах журам"-ыг тус тус шинэчлэн баталсан.

**Хоёр. Агаарын тээврийн эдийн засгийн зохицуулалт, гадаад хамтын ажиллагааны чиглэлээр:**

"Жапан Эйрлайнс" компаниас ирүүлсэн "МИАТ" ТӨХК-тай хамтран Улаанбаатар-Нарита-Улаанбаатар, Улаанбаатар-Осака-Улаанбаатар, Улаанбаатар-Пусан-Улаанбаатар чиглэлд өөрийн нислэгийн дугаартай тийз борлуулах хүсэлтийг судлан үзэж Монгол Улс, Япон Улсын иргэний нисэхийн удирдах байгууллагууд хооронд 2013 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр байгуулсан Уулзалтын тэмдэглэлийн 3 дугаар зүйлийн дагуу "Жапан Эйрлайнс" компанид "МИАТ" ТӨХК-тай хамтран Улаанбаатар-Нарита-Улаанбаатар, Улаанбаатар-Осака-Улаанбаатар, Улаанбаатар-Пусан-Улаанбаатар чиглэлд маркетингийн агаарын тээвэрлэгчийн зөвшөөрлийг 2020 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 01/31 тоот албан бичгээр олгосон.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас 2020 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 1/477 тоот албан бичгээр Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам хооронд байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн дагуу Хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хугацаандаа ээлжийн амралт авсан болон ажлын байр солих хүсэлт гаргаж хүлээлгэд байгаа үедээ эх орондоо түр хугацаагаар ирсэн 56 иргэнийг БНСУ-руу тусгай үүргийн онгоцоор буцах хүсэлт ирүүлснийг "МИАТ" ТӨХК-д уламжлан дээрх иргэдийг тээвэрлэх боломжийн талаар судалж хариу ирүүлэхийг мэдэгдсэн бөгөөд "МИАТ" ТӨХК 2020 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн 05/647 тоот албан бичгээр Монгол Улсын Засгийн газрын 102 дугаар тогтоол болон Улсын Онцгой Комиссын хуралдааны шийдвэрээр өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 4 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл сунгаж хилийн бүх боомтоор нэвтрэх зорчигч тээврийн хөдөлгөөнийг зогсоосонтой холбогдуулан дээрх хугацаанд нислэг үйлдэх өдрийг "МИАТ" ТӨХК тогтоохгүй бөгөөд Улсын Онцгой комиссоос өгсөн үүрэг даалгаврын дагуу ажиллаж байгаа мэдэгдэн Улсын Онцгой комиссоос захиалгат нислэг үйлдэх удирдамж ирвэл тухай бүрд суудлын боломжоор Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас ирүүлсэн БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллах иргэдийг Улаанбаатар-Сөүл чиглэлд тээвэрлэхээ мэдэгдсэнийг 2020 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн 07/778 тоот албан бичгээр Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт уламжлан хүргүүлсэн.

Монгол Улс, Япон Улс хоорондын нислэгийн давтамж нэмэгдүүлэхээр Японы талтай харилцан ажиллаж байгаа бөгөөд Японы талаас харилцан албан бичгээр давтамж нэмэгдүүлэх боломжтой тухай мэдэгдсэн. Тус газрын зүгээс агаарын тээвэрлэгчдийн саналыг нэгтгэн Япон Улсын давтамж нэмэх, чиглэл авах тухай 01/1546 тоот албан бичгийг 2020 оны 6 дугаар сарын 15-ны өдөр ЗТХЯ-нд хүргүүлээд байна.

Хүнгүй агаарын хөлгийн үйл ажиллагааны чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлэгч Канад Улсын "Helios UAV" компанитай байгуулах Хамтран ажиллах гэрээний төсөлд ИНЕГ-ын Даргын зөвлөлийн гишүүдийн саналыг авч төслийг эцэслэн боловсруулж Гадаад харилцааны яамнаас зөвшөөрөл авахад бэлэн болгосон.

Хүнгүй агаарын хөлгийн үйл ажиллагаа, ашиглалтын чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлдэг Канад Улсын "Helios UAV" компанитай Хүнгүй агаарын хөлгийн үйл ажиллагаанд холбогдох дүрмийн зохицуулалтыг сайжруулах, хүнгүй агаарын хөлгийг олон салбарт ашиглах үзэл баримтлал боловсруулах чиглэлээр хамтран ажиллах "Хамтын ажиллагааны гэрээ"-ний төслийг боловсруулж "Байгууллага хоорондын гэрээ байгуулах журам"-д заасны дагуу Гадаад харилцааны яамнаас зөвшөөрөл авахаар 2020 оны 8 дугаар сарын 05-ны 01/2051 тоот албан бичгээр хүргүүлсэн.

АНУ-ын төрийн департамент болон Монгол Улсын Гадаад харилцааны яамны хооронд жил бүр зохион байгуулагддаг ээлжит өндөр түвшний хурал Ковид-19-ын улмаас цахим хэлбэрээр 2020 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн 19:00-22:00 цагийн хооронд ГХЯ-нд зохион байгуулагдсан бөгөөд хоёр улсын хоорондын агаарын тээврийн талаарх хэлэлцүүлэгт ЗТХЯ, ИНЕГ-аас холбогдох албан тушаалтнууд оролцсон.

БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонконгтой байгуулсан Агаарын харилцааны хэлэлцээрт өөрчлөлт оруулан Улаанбаатар-Хонконгийн чиглэлд 7 хоногт үйлдэгдэх нислэгийн давтамжийг нэмэгдүүлэх хүсэлтийг 2020 оны 10 дугаар сарын 12-ны өдөр цахимаар хүргүүлсэн.

**Агаарын харилцааны хэлэлцээр**



Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Агаарын харилцааны хэлэлцээрийн ICAN 2018 арга хэмжээний үеэр үзэглэсэн Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Канад Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг шинэчлэх саналаа Канад Улсын Гадаад харилцааны яаманд 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 07/44 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Бүгд Найрамдах Кени Улсын Найроби хотноо 2018 оны 12 дугаар сард Монгол Улс болон Испанийн Вант Улсын Нисэхийн удирдах байгууллагуудын хооронд үзэглэсэн Агаарын харилцааны хэлэлцээрт Испанийн талаас нэмэлт өөрчлөлт оруулан дипломат шугамаар ирүүлсэн бөгөөд уг нэмэлт өөрчлөлтийн танилцуулга, орчуулгыг хийн хэлэлцээрийн талаар цаашид хэрэгжүүлэх ажлын талаар чиглэл авахаар ЗТХЯ-ны АТБХЗГ-ын дарга Ч.Мөнхтуяад 2020 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн 01/2097 дугаартай албан бичгээр хүсэлт хүргүүлсэн.

Индонез, Филиппин, Малайз, Финлянд, Румын, Польш, Унгар, Исланд, Франц Улсуудтай аяллын дугаар хуваан ашиглах зохицуулалт бүрдүүлэх саналаа ЗТХЯ-нд 2020 оны 8 дугаар сарын 20-ны 01/2199 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Гадаад харилцааны сайд Н.Энхтайван Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн нар болон НҮБ, НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудын суурин төлөөлөгч нартай харилцаа хамтын ажиллагаанд тулгамдаад буй асуудлаар санал солилцсонтой холбогдуулан Монгол, Вьетнамын хооронд шууд нислэг нээх асуудал, Монгол Улс, Арабын Нэгдсэн Эмират Улсын хооронд шууд нислэг үйлдэх асуудал, АНУ-тай “Нээлттэй агаарын зайн хэлэлцээр” байгуулах асуудлын талаарх саналыг тус тус 2020 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн 01/2369 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн.

МИАТ” ТӨХК-с АНУ-тай хоёр талт агаарын харилцааны хэлэлцээр байгуулах тухай санал ирүүлснийг АНУ руу нислэг үйлдэх тооцоо судалгааны хамт 2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 01/2984 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн.

#### Олон улсын нислэгийн чиглэлд агаарын тээвэрлэгчийг томилох

Оросын Холбооны Улс (ОХУ)-ын Тээврийн яамнаас хоёр орны хооронд нислэг гүйцэтгэх агаарын тээвэрлэгчийн тоог хязгаарлахгүй байх зарчмыг тохиролцох санал ирүүлсний дагуу тус газрын зүгээс олон улсын хуваарьт нислэг гүйцэтгэдэг “МИАТ” ТӨХК, “Аэромонголиа” ХХК, “Хүннү Эйр” ХХК, “Изинис Эйрвэйс” ХХК-иудаас холбогдох саналууд авсан бөгөөд Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан агаарын тээврийн салбарын нөхцөл байдал хүнд байгаа тул агаарын тээврийн зорчигч урсгал сайжирч, үйл ажиллагаа жигдрэх хүртэл Улаанбаатар-Москва, Улаанбаатар-Эрхүү чиглэлээс бусад чиглэлд агаарын тээвэрлэгчийн тоог хязгаарлахгүй байх мөн ОХУ-ын талаас Нордстар компанийг Красноярск-Улаанбаатар-Красноярск чиглэлд нислэг гүйцэтгэх агаарын тээвэрлэгчээр томилох бөгөөд Монголын талаас “Хүннү Эйр” ХХК Улаанбаатар-Кызыл-Улаанбаатар чиглэлд нислэг гүйцэтгэхээр төлөвлөн томилогдох хүсэлтээ ирүүлсэнтэй холбогдуулан Красноярск, Кызыл цэгүүдийг ОХУ дахь цэгээр тогтоох саналыг ЗТХЯ-нд 2020 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 01/1304 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Агаарын харилцааны тухай хэлэлцээр хийх, байгуулсан агаарын харилцааны хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулах зорилгоор Индонез, Филиппин, Малайз, Финлянд, Румын, Польш, Унгар, Исланд, Франц Улсуудтай аяллын дугаар хамтран ашиглах зохицуулалт тохирохоор төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд тус зохицуулалтын төсөлтэй танилцаж, холбогдох чиглэл өгөхийг ЗТХЯ-наас 2020 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 01/1393 тоот албан бичгээр хүссэн.

Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрт Шэньжэнь хотыг нисэн очих цэгээр тохирсон тохиолдолд Улаанбаатар-Шэньжэнь-Улаанбаатар чиглэлд шууд нислэг нээх зорилгоор “Аэромонголиа” ХХК-ийг тухайн чиглэлд томилох боломжтой тухай саналыг 2020 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 01/1394 тоот албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн.

#### Гурав. Нисэхийн аюулгүй ажиллагааны болон аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын чиглэлээр:

Монгол Улсын иргэний агаарын хөлгийн бүртгэлд агаарын хөлгийг бүртгэх, бүртгэлээс хасах, Иргэний агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэх болон иргэний нисэхийн үйлчилгээний байгууллага, хувь хүн, иргэний нисэхэд ашиглах бүтээгдэхүүнд зөвшөөрөл, гэрчилгээ олгох, түдгэлзүүлэх, хүчинтэй хугацааг сунгах, үйл ажиллагаанд нь тогтмол хяналт тавих, Аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын үзлэг шалгалтыг тогтмол хийж, стандартуудыг мөрдүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

2020 онд байгууллагуудаас ирүүлсэн 420 баримт бичгийн хяналтын ажлыг гүйцэтгэж, 633 байцаагчийн дүгнэлт гаргасан. Гэрчилгээжсэн болон зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудад төлөвлөгөөт **138**, төлөвлөгөөт бус **148** үзлэг шалгалтуудыг тус тус хийж гүйцэтгэсэн.

#### **Гэрчилгээжүүлэлтийн талаар:**

**ИНД-119-ийн хүрээнд агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ шинээр олголт-1, сунгалт-1, эзэмшигчийн нэр өөрчлөх-1, хураасан-1:**

1. “Тэнгэрийн Улаач Шинэ” ХХК-д АТ-029 дугаартай Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээг, хавсралт Үйл ажиллагааны тодорхойлолтын хамт 3 жилээр олгосон. /2020.02.20-2023.02.19/

2. “МИАТ” ТӨХК-д АТ-003 дугаартай Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний хүчинтэй хугацааг 3 жилээр сунгаж олгосон. /2020.05.21-2023.05.19/



3. **“Монголиан Эйрвейс” ХХК-д** АТ-030 дугаартай Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээг, хавсралт Үйл ажиллагааны тодорхойлолтын хамт 3 жилээр олгосон. олгосон. /2020.07.10-2023.07.09/

4. АТ-014 дугаартай Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшдэг Монголын Алт “МАК” ХХК нь “Хүннү Эйр” ХХК-д нэгдсэнтэй холбогдуулан Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ, түүний хавсралт Үйл ажиллагааны тодорхойлолтонд заагдсан МАК ХХК-ийн нэршлийг **“Хүннү Эйр” ХХК** /Бизнесийн нэр Хүннү Авиэйшн/ болгон өөрчилж, А05 “Удирдах албан тушаалтан” хэсэгт өөрчлөлт оруулан олгосон. /2020.04.29-2022.03.30/

**ИНД-129 гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ сунгалт – 3:**

1. **“SCAT”** компанид FAOC-015 дугаартай гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээг 5 жилээр сунгаж олгосон. /2020.05.21-2025.05.20/

2. **“Asiana Airlines”** компанид FAOC-018 дугаартай гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээг 5 жилээр сунгаж олгосон. /2020.05.25-2025.05.23/

3. **“Air Busan”** компанид FAOC-012 дугаартай гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээг 1 жилээр сунгаж олгосон. /2020.10.12-2021.10.11/

**ИНД-21 Агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ шинээр олголт – 2, гэрчилгээнд өөрчлөлт оруулалт – 1, гэрчилгээ сунгалт – 16,**

**ИНД-145 дүрмийн хүрээнд Агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээ шинээр олголт – 1, сунгалт – 9:**

1. **“Тэнгэрийн Улаач Шинэ” ХХК-д** 6 сарын хугацаатай гэрчилгээг шинээр олгосон. /2020.08.13-2021.02.12/

2. **“Геосан” ХХК-ийн** гэрчилгээг 1 сараар сунгасан. /MCAA.145. 1713 2020.04.03-2020.05.02/

3. **“Хүннү Эйр” ХХК-ийн** гэрчилгээг 6 сараар сунгасан. /MCAA.145. 0908 2020.04.09-2020.10.08/

4. **“Аэро Монголиа” ХХК-ийн** гэрчилгээг 6 сараар сунгасан. /MCAA.145. 1209 2020.05.27-2020.10.27/

5. **“Изинис Эйрвейз” ХХК-ийн** гэрчилгээг 6 сараар сунгасан. /MCAA.145. 1819 2020.09.23-2021.03.22/

6. **“Геосан” ХХК-ийн** гэрчилгээг 6 сараар сунгасан. /MCAA.145. 1713 2020.05.12-2020.11.11/

7. **“Монголиан Эйрвейс” ХХК-ийн** гэрчилгээг 6 сараар сунгасан. /MCAA.145. 2020 2020.07.09-2021.01.08/

8. **“Хүннү Эйр” ХХК-ийн** гэрчилгээг 6 сараар сунгасан. /MCAA.145. 0908 2020.10.07-2021.04.07/

9. **“Аэро Монголиа” ХХК-ийн** гэрчилгээг 1 жилээр сунгасан. /MCAA.145. 1209 2020.10.26-2021.10.25/

10. **“Геосан” ХХК-ийн** гэрчилгээг 6 сараар сунгасан. /MCAA.145. 1713 2020.11.10-2021.05.08/

**ИНД-144 дүрмийн хүрээнд Шатахуун хангамжийн байгууллагын гэрчилгээг шинээр олголт – 1, сунгалт-5**

**ИНД-139 Аэродромын гэрчилгээ сунгалт-13, хүчингүй болгох -1:**

1. **“Ханбумбат”** нисэх буудлын аэродромын гэрчилгээний хугацааг 2021.04.30-ны өдөр хүртэл 1 жилээр сунгаж олгосон.

2. **“Чойбалсан”** нисэх буудлын аэродромын гэрчилгээний хугацааг 2020.10.30-ны өдөр хүртэл, 2022.07.15-ны өдөр хүртэл тус тус 2 удаа сунгасан.

3. **“Гурвансайхан”** нисэх буудлын аэродромын гэрчилгээний хугацааг 2020.07.30-ны өдөр хүртэл 2 сараар, 2020.10.13-ны өдрөөс 2021.10.13-ны өдөр хүртэл 1 жилийн хугацаатай, нийт 2 удаа сунгасан.

4. **“Мөрөн”** нисэх буудлын аэродромын гэрчилгээний хугацааг 2021.05.31-ний өдөр хүртэл 1 жилээр сунгасан.

5. **“Чингис хаан” ОУНБ** (одоогийн Буянт-Ухаа ОУНБ)-ын аэродромын гэрчилгээний хугацааг 2020.07.01-ны өдөр хүртэл, мөн 2021.12.01-ний өдөр хүртэл 1 жилийн хугацаатай 2 удаа тус тус сунгасан.

6. **“Дэглий цагаан”** нисэх буудлын аэродромын гэрчилгээний хугацааг 2021.06.25-ны өдөр хүртэл сунгасан.

7. **“Өлгий”** нисэх буудлын аэродромын гэрчилгээний хугацааг 2021.07.31-ний өдөр хүртэл 1 жилээр сунгасан.

8. **“Баянхонгор”** нисэх буудлын аэродромын гэрчилгээний хугацааг 2021.07.31-ний өдөр хүртэл 1 жилээр сунгасан.

9. **“Доной”** нисэх буудлын аэродромын гэрчилгээний хугацааг 2021.09.01-ний өдөр хүртэл 1 жилээр сунгасан.

10. **“Ховд”** нисэх буудлын аэродромын гэрчилгээний хугацааг 2021.04.01-ний өдөр хүртэл 6 сараар сунгасан.

**ИНД-140 дүрмийн хүрээнд нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээний байгууллагын гэрчилгээ шинээр олголт – 1, хугацаа сунгалт – 14:**

1. Иргэний нисэхийн үндэсний төвд 2020 оны 04 сарын 10-ны өдрөөс 6 сарын хугацаатай 140-20 дугаартай Нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээний байгууллагын гэрчилгээг олгосон олгож, гэрчилгээний хугацааг 2021.01.10-ны өдөр хүртэл 3 сараар сунгаж олгосон.

2. **“Өлгий”** нисэх буудлын нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээний байгууллагын гэрчилгээг 2020.10.30-ны өдөр хүртэл, 2021.04.30-ны өдөр хүртэл тус тус сунгасан.

3. **“Алтай”** нисэх буудлын нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээний байгууллагын гэрчилгээний хугацааг 2020.12.03-ны өдөр хүртэл, 2021.06.03-ны өдөр хүртэл тус тус сунгасан.

4. **“Чойбалсан”** нисэх буудлын аюулгүй байдлын үйлчилгээний байгууллагын гэрчилгээний хугацааг 2020.12.01-ний өдөр хүртэл, 2021.06.01-ний өдөр хүртэл тус тус сунгасан.





5. “Эй Си Эйч Сервисес” ХХК-ийн 140-18 дугаартай аюулгүй байдлын үйлчилгээний байгууллагын гэрчилгээний хугацааг 2020.07.22-ны өдөр хүртэл, 2020.12.12-ны өдөр хүртэл, 2021.03.12-ны өдөр хүртэл тус тус сунгасан.

6. “Баянхонгор” нисэх буудлын 140-14 дугаартай гэрчилгээний хугацааг 2020.10.01-ний өдөр хүртэл, 2021.04.01-ний өдөр хүртэл 2 удаа сунгасан.

7. “Мөрөн” нисэх буудлын 140-08 дугаартай гэрчилгээний хугацааг 2021.03.28-ны өдөр хүртэл сунгасан.

8. “Ховд” нисэх буудлын 140-05 дугаартай гэрчилгээний хугацааг 2021.04.01-ний өдөр хүртэл сунгасан.

9. “Доной” нисэх буудлын 140-04 дугаартай гэрчилгээний хугацааг 2021.04.15-ны өдөр хүртэл сунгасан.

**ИНД-171-ийн дагуу** Холбоо, навигаци, ажиглалтын албаны Агаарын навигацийн үйлчилгээний техникийн байгууллагын 171-01 дугаартай гэрчилгээний хугацааг 2021.10.16-ны өдөр хүртэл сунгасан.

**ИНД-172-ын дагуу** Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны 172-01 дугаартай гэрчилгээний хугацааг 2020.12.10-ны өдөр хүртэл, 2021.12.10-ны өдөр хүртэл тус тус сунгасан.

**ИНД 173-ын дагуу** Нислэгийн журам боловсруулалтын албаны 173-01 дугаартай гэрчилгээний хугацааг 2020.09.15-ны өдөр хүртэл, 2021.03.15-ны өдөр хүртэл тус тус сунгасан.

**ИНД-174-ийн дагуу** Холбоо навигаци, ажиглалтын албанд нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагын 174-02 дугаартай анхан шатны гэрчилгээг 2020 оны 8 дугаар сарын 12-ноос 6 сарын хугацаатай шинээр олгож, Нислэгийн цаг уурын төвийн 174-01 дугаартай гэрчилгээний хугацааг 2021.03.05-ны өдөр хүртэл сунгасан.

**ИНД-175-ын дагуу** Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албаны 175-01 дугаартай гэрчилгээний хугацааг 2020.12.01-ний өдөр хүртэл, 2023.06.01-ний өдөр хүртэл тус тус сунгасан.

**ИНД-61: Нисгэгчийн үнэмлэх зэрэглэл сунгалт-130**

**ИНД-65: Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ажилтны үнэмлэх зэрэглэл сунгалт-208**

**ИНД-66: Агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтны шинэчилсэн үнэмлэх зэрэглэл сунгалт-131**

**ИНД-67: Эрүүл мэндийн гэрчилгээ олголт-272**

**Итгэмжлэгдсэн эрүүл мэндийн шалгагч гэрээ сунгалт-2**

**ИНД-119, ИНД-121, ИНД-135-ын хүрээнд агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ сунгалт – 1:**

Агаарын тээвэрлэгч	Гэрчилгээний дугаар	Сунгасан огноо	Дуусах огноо
“МИАТ” ХХК	АТ-003	2020.05.21	2023.05.19

**Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ шинээр олголт – 2:**

Агаарын тээвэрлэгч	Олгосон огноо	Дуусах огноо
“Тэнгэрийн улаач шинэ” ХХК	2020.02.20	2023.02.19
“Монголиан Эйрвэйс” ХХК	2020.07.10	2023.07.09

**ИНД-119 дүрмийн хүрээнд агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний үйл ажиллагааны тодорхойлолтод орсон өөрчлөлтүүд**

Агаарын тээвэрлэгч байгууллага	Үйл ажиллагааны тодорхойлолтод орсон өөрчлөлт
“МИАТ” ХК	<p>Үйл ажиллагааны тодорхойлолтын С01 “Хуваарьт нислэгт зөвшөөрөх нисэх буудлууд” хэсэгт Shanghai Pudong Int'l нисэх буудлыг нэмсэн.</p> <p>EI-FGN бүртгэлийн дугаартай B767-300 маягийн хөлгийн зорчигчийн бүхээгт ачаа тээвэрлэх хүсэлт гаргасантай холбогдуулан үзлэг шалгалтыг гүйцэтгэж, Үйл ажиллагааны тодорхойлолтын А03 “Зөвшөөрөгдсөн агаарын хөлгүүд” хэсэгт EI-FGN бүртгэлийн дугаартай агаарын хөлгийн Үйл ажиллагааны төрөл /24C/150Y эсхүл “Зөвхөн эмнэлгийн хэрэгсэл” ачаа/-д нэмэлт өөрчлөлт оруулсан.</p> <p>U-1015 болон JU-1021 бүртгэлийн дугаартай агаарын хөлгүүдийн зорчигчийн бүхээгт ачаа тээвэрлэх хүсэлт гаргасантай холбогдуулан үзлэг шалгалтыг гүйцэтгэж, зөвхөн ‘эмнэлгийн хэрэгсэл’ ачаа тээвэрлэх зөвшөөрөл олгож, Үйл ажиллагааны тодорхойлолтын А03 “Зөвшөөрөгдсөн агаарын хөлгүүд” хэсэгт өөрчлөлт оруулсан.</p> <p>Үйл ажиллагааны тодорхойлолтын С02 “Хуваарьт бус нислэгийн зөвшөөрөл” хэсэгт БНХАУ-ын “Xi'an Xianyang Airport”, “Baita China Airport”-г нэмсэн.</p> <p>Үйл ажиллагааны тодорхойлолтын С01 “Хуваарьт нислэгт зөвшөөрөгдөх нисэх буудлууд” хэсэгт БНХАУ-ын “Baita China Airport”-г нэмсэн.</p> <p>JU-1021 бүртгэлийн дугаартай агаарын хөлгийн зорчигчийн бүхээгт ерөнхий зориулалтын ачаа тээвэрлэх хүсэлт гаргасантай холбогдуулан үзлэг шалгалтыг</p>



<p>“Аэромонголиа” ХХК</p>	<p>гүйцэтгэж, энгийн ачаа тээвэрлэх зөвшөөрөл олгож, Үйл ажиллагааны тодорхойлолтын А03 “Зөвшөөрөгдсөн агаарын хөлгүүд” хэсэгт өөрчлөлт оруулсан. EI-FGN бүртгэлийн дугаартай агаарын хөлгийн зорчигчийн бүхээгт ачаа тээвэрлэх хүсэлт гаргасантай холбогдуулан үзлэг шалгалтыг гүйцэтгэж, энгийн ачаа тээвэрлэх зөвшөөрөл олгож, Үйл ажиллагааны тодорхойлолтын А03 “Зөвшөөрөгдсөн агаарын хөлгүүд” хэсэгт өөрчлөлт оруулсан.</p> <p>JU-1802 бүртгэлийн дугаартай EMB-145LR маягийн агаарын хөлгийг TDB Leasing компаниас 3 жилийн хугацаагаар түрээслэн авч байгаатай холбогдуулан Үйл ажиллагааны тодорхойлолтын А10 “Агаарын хөлгийн түрээс” хэсэгт өөрчлөлт оруулсан. /Түрээсийн хугацаа: 2019.04-2022.04/</p> <p>Техникийн үйл ажиллагаа хариуцсан албан тушаалтан /П.Бат-Эрдэнэ/-г хүлээн зөвшөөрч, Үйл ажиллагааны тодорхойлолтын А05 “Удирдах албан тушаалтан” хэсэгт өөрчлөлт оруулсан.</p>
<p>“Хүннү эйр” ХХК</p>	<p>Нислэгийн үйл ажиллагаа болон нисэх багийн сургалт, дадлага хариуцсан албан тушаалд агаарын хөлгийн дарга М.Төгөлдөрийг хүлээн зөвшөөрч, Үйл ажиллагааны тодорхойлолтын А05 “Удирдах албан тушаалтан” хэсэгт өөрчлөлт оруулсан.</p> <p>Алматы, Бишкек, Владивосток чиглэлүүдийг нэмүүлэх хүсэлтийн дагуу Үйл ажиллагааны тодорхойлолтын В01 “Чиглэлийн дагуух газар нутагт хамаарах зөвшөөрөл болон хязгаарлалтууд”, В04 “RVSM бүхий агаарын орон зайд явуулах нислэгийн үйл ажиллагаа”, С01 “Олон улсын нислэгт зөвшөөрөх нисэх буудлууд” хэсгүүдэд нэмэлт өөрчлөлт оруулсан.</p>
<p>“Изинис эйрвэйз” ХХК</p>	<p>Нислэгийн үйл ажиллагаа хариуцсан албан тушаалтан /З.Энхбаяр/ болон нисэх багийн сургалт, дадлага хариуцсан албан тушаалтанг /Б.Болд/ хүлээн зөвшөөрч, Үйл ажиллагааны тодорхойлолтын А05 “Удирдах албан тушаалтан” хэсэгт өөрчлөлт оруулсан.</p> <p>Улаанбаатар-Бусан-Улаанбаатар чиглэлд хуваарьт тогтмол нислэг үйлдэх болсонтой холбогдуулан Үйл ажиллагааны тодорхойлолтын С01 “Хуваарьт нислэгт зөвшөөрөх нисэх буудлууд” хэсэгт өөрчлөлт оруулсан.</p> <p>Тус компанийн хүсэлтийн дагуу Үйл ажиллагааны тодорхойлолтын зөвшөөрөгдсөн газар нутагт Европыг нэмж дараах хэсгүүдэд өөрчлөлт оруулсан:</p> <ul style="list-style-type: none"> <li>– Нүүр хуудас,</li> <li>– В01 /Чиглэлийн дагуух газар нутагт хамаарах зөвшөөрөл болон хязгаарлалтууд/,</li> <li>– В02 /Багасгасан босоо цуваачлал (RVSM) бүхий агаарын орон зайд явуулах нислэгийн үйл ажиллагаа/</li> </ul> <p>Тус компани EI-ULN бүртгэлийн дугаартай В737-700 агаарын хөлгөөр ачаа тээвэрлэх хүсэлт гаргасантай холбогдуулан үзлэг шалгалтыг гүйцэтгэж, Үйл ажиллагааны тодорхойлолтын А003 “Зөвшөөрөгдсөн агаарын хөлгүүд” хэсэгт өөрчлөлт оруулсан.</p> <p>Тус компани EI-ULN бүртгэлийн дугаартай В737NG маягийн агаарын хөлгөөр Холбооны Бүгд Найрамдах Нигери Улсад нойтон түрээсээр нисэх хүсэлт ирүүлсний дагуу холбогдох баримт материалд хяналт тавьж, Үйл ажиллагааны тодорхойлолтын А10 “Агаарын хөлгийн нойтон түрээс”, В01 “Чиглэлийн дагуух газар нутагт хамаарах зөвшөөрөл болон хязгаарлалтууд”, В02 “Багасгасан босоо цуваачлал бүхий агаарын орон зайд явуулах нислэгийн үйл ажиллагаа” хэсгүүдэд нэмэлт өөрчлөлт оруулсан.</p>
<p>“Монголиан Эйрвейс Карго” ХХК</p>	<p>Үйл ажиллагааны тодорхойлолтын В01 “Чиглэлийн дагуух газар нутагт хамаарах зөвшөөрөл болон хязгаарлалтууд” хэсэгт Хойд америкийг нэмсэн.</p> <p>Үйл ажиллагааны тодорхойлолтын А03 “Зөвшөөрөгдсөн агаарын хөлгүүд” хэсэгт JU-8888 бүртгэлийн дугаартай В737-300SF маягийн агаарын хөлгийг нэмж, JU-8889 бүртгэлийн дугаартай В737-300 маягийн агаарын хөлгийг хассан.</p>

### ИНД-129 гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ сунгалт – 3:

Гадаадын агаарын тээвэрлэгч	Гэрчилгээний дугаар	Сунгасан огноо	Дуусах огноо
“SCAT”	FAOC-015	2020.05.21	2025.05.20
“Asiana airlines”	FAOC-018	2020.05.25	2025.05.23
“Air Busan”	FAOC-012	2020.10.12	2021.10.11

ИНД-129 дүрмийн хүрээнд гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний үйл ажиллагааны тодорхойлолтод орсон өөрчлөлтүүд – 3:



Агаарын тээвэрлэгч байгууллага	Үйл ажиллагааны тодорхойлолтод орсон өөрчлөлт
"Aeroflot"	Үйл ажиллагааны тодорхойлолтын А003 "Aircraft Authorizations" хэсэгт А-320-214, А-321-211, А-330-343 маягийн 10 агаарын хөлөг нэмж бүртгэсэн.
"Air Busan"	Үйл ажиллагааны тодорхойлолтын А003 "Aircraft Authorizations" хэсэгт HL8366 бүртгэлийн дугаартай А321-200 маягийн агаарын хөлгийг нэмж бүртгэсэн.
"Air China"	Үйл ажиллагааны тодорхойлолтын А006 "Гадаадын иргэний нисэхийн ерөнхий газрыг төлөөлөх" хэсэгт нэмэлт өөрчлөлтийг оруулсан.

**ИНД-47 Агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээ олголт – 5:**

№	Эзэмшигч	Агаарын хөлгийн маяг	Бүртгэлийн дугаар	Бүртгэлд авсан огноо
1	"Монголиан Эйрвейс Карго" ХХК	B737-300SF	JU-8888	2019.12.30
2	"Монголиан Эйрвейс" ХХК	AS 350B3	JU-6888	2020.05.11
3	"Сатурн Экстрем Монголиа" ХХК	AT104-70AT	JU-7799	2020.08.10
4	"Монголиан Эйрвейс Карго" ХХК	B737-300	JU-8890	2020.09.21
5	"Монголиан Эйрвейс" ХХК	AS 350B3	JU-6889	2020.09.23

**ИНД-47 Агаарын хөлгийг бүртгэлээс хассан гэрчилгээ – 3:**

№	Эзэмшигч	Агаарын хөлгийн маяг	Бүртгэлийн дугаар	Бүртгэлээс хассан огноо
1	"Томас Эйр" ХХК	King Air C90	JU-1911	2020.01.30
2	Блу скай авиэйшн ХХК	Cessna-208B	JU-2114	2020.03.13
3	"Монголиан Эйрвейс Карго" ХХК	B737-300SF	JU-8889	2020.07.21

**ИНД-47 Агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээнд өөрчлөлт оруулсан – 1:**

№	Агаарын хөлгийн эзэмшигч	Агаарын хөлгийн маяг	Бүртгэлийн дугаар	Өөрчлөлт орсон огноо
1	"Хүннү Эйр" ХХК	Ми-8АМТ	JU-6601	2020.06.02

**ИНД-47 Агаарын хөлгийн будган зургийн зөвшөөрөл – 5:**

№	Агаарын хөлгийн эзэмшигч	Агаарын хөлгийн маяг	Бүртгэлийн дугаар	Зөвшөөрөл олгосон огноо
1	"Монголиан Эйрвейс Карго" ХХК	B737-300SF	JU-8888	2019.12.30
2	"Монголиан Эйрвейс" ХХК	AS 350B3	JU-6888	2020.05.11
3	"Аэро Монголиа" ХХК	EMB-145	JU-1800	2020.08.12
4	"Хүннү Эйр" ХХК	Ми-8АМТ	JU-6601	2020.09.22
5	"Монголиан Эйрвейс" ХХК	AS 350B3	JU-6889	2020.09.22

**ИНД-21 Агаарын хөлгийн Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ шинээр олгосон - 2, сунгалт – 17:**

№	Эзэмшигч	Агаарын хөлгийн маяг	Бүртгэлийн дугаар	НТЧ сунгасан огноо	Хүчинтэй хугацаа
1	Блу Скай Авиэйшн ХХК	Cessna-208B	JU-2114	2020.01.09	2020.07.09
2	Тэнгэрийн Улаач Шинэ ХХК	Cessna-208B	JU-9999	2020.02.04	2021.02.03
3	Скай Жет ХХК	Cessna-208B	JU-7777	2020.03.17	2021.03.16
4	Томас Эйр ХХК	Airtractor AT-602	JU-1918	2020.03.20	2020.03.19
5	Вельталь Авиа Стар ХХК	Ан-2	JU-9069	Их биеийн хугацаа дууссан.	
6	Геосан ХХК	Cessna-208B	JU-9993	2020.04.17	2021.04.16
7	Геосан ХХК	Cessna-208B	JU-9991	2020.05.12	2020.11.11
8	Хүннү Эйр ХХК	ERJ190-100LR	JU-8811	2020.05.21	2020.11.20
9	МИАТ ХК	B737-800	JU-1015	2020.05.26	2021.05.25
10	АэроМонголиа ХХК	EMB-145LR	JU-1800	2020.05.29	2020.11.28
11	Хүннү Эйр ХХК	ATR-72-212A	JU-8801	2020.06.17	2021.06.16
12	АэроМонголиа ХХК	EMB-145LR	JU-1802	2020.06.29	2021.06.28





13	МИАТ ХК	B737-800	JU-1088	2020.11.17	2021.11.16
14	МИАТ ХК	B737-300	JU-1021	2020.11.27	2021.11.26
15	Хүннү Эйр ХХК	ATR72-212A	JU-8802	Компаниас ирүүлсэн хүсэлтийн дагуу хойшлуулсан	
16	Вельталь Авиа-Стар ХХК	An-2	JU-9069	Их биеийн хугацаа дууссан.	
17	Монголиан Эйрвейс Карго ХХК	B737-300 SF	JU-8889	МУ-ын бүртгэлээс хассан.	
18	Тэнгэрийн Улаач Шинэ ХХК	Cessna-208B	JU-9999	2020.03.31	2021.02.03
19	Хүннү Эйр ХХК	МИ-8АМТ	JU-6601	2020.06.10	2020.07.09
20	Монголиан Эйрвейс ХХК	AS 350B3	JU-6888	2020.06.19	2020.12.18
21	Хүннү Эйр ХХК	МИ-8АМТ	JU-6601	2020.07.09	2021.01.08
22	Монголиан Эйрвейс ХХК	AS 350B3	JU-6889	2020.09.25	2021.03.24
23	Хүннү Эйр ХХК	ERJ190-100LR	JU-8811	2020.11.19	2021.11.18

**ИНД-21 Агаарын хөлгийн маягийг хүлээн зөвшөөрсөн гэрчилгээ – 6:**

№	Гэрчилгээний дугаар	Агаарын хөлгийн маяг	Маягийг хүлээн зөвшөөрсөн огноо
1	3/21В/20	AS 350 B3	2020.01.03
2	4/21В/20	Model 172S	2020.07.08
3	5/21В/20	AT104 Hot air balloon	2020.07.21
4	6/21В/20	Model 269C, 269C-1	2020.10.02
5	6/21В/20	TAE 125-02-99; TAE 125-02-114	2020.09.09
6	7/21В/20	Cabri G2	2020.12.01

**ИНД-21 Агаарын хөлгийн радио станцын болон дуу чимээний зөвшөөрөл – 4:**

№	Агаарын хөлгийн эзэмшигч	Агаарын хөлгийн маяг	Бүртгэлийн дугаар	Радио станцын зөвшөөрөл олгосон огноо	Дуу чимээний зөвшөөрөл олгосон огноо
1	“Монголиан Эйрвейс” ХХК	AS 350B3	JU-6888	2020.05.12	2020.05.12
2	“Хүннү Эйр” ХХК	Ми-8АМТ	JU-6601	2020.09.04	
3	“Монголиан Эйрвейс” ХХК	AS 350B3	JU-6889	2020.10.06	2020.10.06
4	“Монголиан Эйрвейс Карго” ХХК	B737-300SF	JU-8888	2020.12.01	2020.12.01

**ИНД-144 Нисэхийн хангамжийн байгууллага гэрчилгээ олгосон – 1, гэрчилгээ сунгалт-5:**

№	Байгууллагын нэр	Гэрчилгээ сунгасан огноо	Хүчинтэй хугацаа
1	“Монголиан Авиэшн фуел” ХХК	2020.02.19	2021.02.18
2	“Магнай Трейд” ХХК	2020.03.17	2021.03.16
3	“Мэргэван” ХХК	2020.04.10	2020.10.09
4	ИНҮТ шинээр олгосон	2020.06.03	2021.06.02
5	“Мэргэван” ХХК	2020.10.09	2020.11.09
6	“Мэргэван” ХХК	2020.11.09	2021.05.07

**ИНД-145 Агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээ шинээр олголт – 2:**

№	Байгууллагын нэр	Гэрчилгээ шинээр олгосон	Хүчинтэй хугацаа
<b>Агаарын хөлгийн дотоодын техник үйлчилгээний байгууллага</b>			
1	Тэнгэрийн улаач шинэ ХХК	2020.02.13	2021.02.12
<b>Агаарын хөлгийн гадаадын техник үйлчилгээний байгууллага</b>			
2	GENEL HAVACILIK A.S. /БНТУ/	2020.01.24	2021.01.23


**ИНД-145 Агаарын хөлгийн техник үйлчилгээний дотоодын байгууллагын гэрчилгээ сунгалт-9, хадгалалтын үзлэг шалгалт-1:**

№	Байгууллагын нэр	Гэрчилгээ сунгасан огноо	Хүчинтэй хугацаа
1	Геосан ХХК	2020.04.03	2020.05.02
2	Хүннү Эйр ХХК	2020.04.09	2020.10.08
3	Геосан ХХК	2020.05.12	2020.11.11
4	АэроМонголиа ХХК	2020.05.28	2020.10.27
5	МАК ХХК	Хүннү Эйр ХХК-д нэгдсэн тул Хүннү Эйр-ийн YAT МИ-8АМТ агаарын хөлөгтэй холбоотой өөрчлөлтийг оруулсан оруулсан.	
6	Изинис Эйрвейз ХХК	2020.09.23	2021.03.22
7	Монголиан Эйрвэйс ХХК	2020.07.09	2021.01.08
8	Хүннү Эйр ХХК	2020.10.07	2021.04.07
9	АэроМонголиа ХХК	2020.10.26	2021.10.25
10	Геосан ХХК	2020.11.10	2021.05.08
11	МИАТ ХК	2020.10.02	

**ИНД-145 Агаарын хөлгийн техник үйлчилгээний гадаадын байгууллагын гэрчилгээ сунгалт-13:**

№	Байгууллагын нэр	Гэрчилгээ сунгасан огноо	Хүчинтэй хугацаа
1	SCAT /Kazakhstan/	2020.04.07	2020.10.06
2	Dallas Airmotive Inc /USA/	2020.05.14	2020.10.01
3	Lufthansa Technik AG /Germany/	2020.05.14	2020.10.01
4	Aircraft Maintenance and Engineering Corporation Beijing – Beijing Base /China/	2020.05.15	2020.10.01
5	AMECO /Beijing Base/	2020.01.10	2020.04.09
6	GDAT Ningbo Company Ltd	2020.02.17	2020.11.13
7	AMECO /Beijing Base/	2020.10.01	2021.10.01
8	CAMECO China Aircraft Maintenance & Engineering Co.,Ltd	2020.10.01	2021.10.01
9	Lufthansa Technik AG	2020.10.01	2021.10.01
10	Shenyang Avias Aviation Maintenance engineering Co,ltd	2020.10.01	2021.10.01
11	Fokker Services Asia Pte Ltd	2020.10.08	2021.10.08
12	JSC Air Company "SCAT", SCAT MRO	2020.10.27	2021.04.26
13	Rheinland Air Service GmbH	2020.10.30	2021.10.29

**ИНД-145 Агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээний Үйл ажиллагааны тодорхойлолтод орсон өөрчлөлт – 4:**

№	Байгууллагын нэр	Өөрчлөлт орсон огноо	Үйл ажиллагааны тодорхойлолтод өөрчлөлт оруулсан
1	Хүннү Эйр ХХК	2020.03.27	EMB190-100LR маягийн агаарын хөлөгт 2А хүртэлх хэлбэрийн техник үйлчилгээг гүйцэтгэх хүсэлт ирүүлсний дагуу үзлэг шалгалт гүйцэтгэн байцаагчийн дүгнэлт гарган YAT-д өөрчлөлт оруулсан
2	Хүннү Эйр ХХК	2020.06.10	МАК ХХК -г татан буулгаж Хүннү Эйр ХХК-тэй нэгтгэсэнтэй холбогдуулан үйл ажиллагааны тодорхойлолтод Ми-8АМТ маягийн нисдэг тэрэгнүүдийн техник үйлчилгээг нэмж оруулсан
3	Тэнгэрийн Улаач Шинэ ХХК	2020.06.30	Үйл ажиллагааны тодорхойлолтод Cessna-208В маягийн агаарын хөлөгт гүйцэтгэх техник үйлчилгээг нэмүүлэх хүсэлт ирүүлсний дагуу холбогдох үзлэг шалгалтыг гүйцэтгэж байна.
4	Изинис Эйрвэйз ХХК	2020.06.22	1А, 2А хэлбэрийн техник үйлчилгээг гүйцэтгэх өөрчлөлт оруулав.

**ИНД-21 Агаарын хөлгийн тусгай нислэгийн зөвшөөрөл – 4:**

№	Эзэмшигч	Агаарын хөлгийн маяг	Бүртгэлийн дугаар	ТНЗ олгосон огноо	Хүчинтэй огноо
1	“Хүннү Эйр”	MI8 AMT	JU6601	2020.06.09	2020.06.16
2	“Монголиан Эйрвейс” ХХК	AS 350B3	JU 6888	2020.06.14	2020.06.20
3	Монголиан Эйрвейс ХХК	AS 350B3	JU-6889	2020.09.25	2020.10.02
4	Монголиан Эйрвейс Карго ХХК	B737-300SF	JU-8888	2020.12.01	2020.12.31

**ИНД-139-ийн дагуу Аэродромын гэрчилгээ сунгалт – 13, хүчингүй болгосон – 1, нисэх буудлын аэродромын гэрчилгээг сунгалт – 1:**

№	ИНД-139	Аэродром эзэмшигч байгууллага	Гэрчилгээнд өөрчлөлт орсон огноо/сунгалт*/	Гэрчилгээний хүчинтэй хугацаа
1	Таван толгой нисэх буудал	Таван толгой нисэх буудал ХХК	2020.02.21	Хүчингүй болгосон
2	Ханбумбат нисэх буудал	Оюу толгой ХХК	2020.04.30	2021.04.30
3	Чойбалсан нисэх буудал	ИНЕГ	2020.04.30 2020.10.30	2021.07.15
4	Гурван сайхан нисэх буудал	ИНЕГ	2020.07.30* 2020.10.13*	2020.07.30, 2021.10.13
5	Мөрөн нисэх буудал	ИНЕГ	2020.05.29*	2021.05.31
6	"Чингис хаан" Олон улсын нисэх буудал /Буянт-Ухаа ОУНБ/	ИНЕГ	2020.05.29* 2020.06.30* 2020.12.01*	2020.06.30 2020.12.01 2021.12.01
7	Хөшигийн хөндий дэх УБОУШНОБ	НУБИЭ ХХК	2020.06.15 2020.09.30	олгоогүй
8	Дэглий цагаан нисэх буудал	ИНЕГ	2020.06.25*	2021.06.25
9	Өлгий нисэх буудал	ИНЕГ	2020.07.30*	2021.07.31
9	Баянхонгор нисэх буудал	ИНЕГ	2020.07.31*	2021.07.31
10	Доной нисэх буудал	ИНЕГ	2020.08.28*	2021.04.15
11	Ховд нисэх буудал	ИНЕГ	2020.09.30*	2021.04.01
12	Овоот нисэх буудал	Саусгоби Сэндс ХХК	2020.04.30	түдгэлзсэн

**ИНД-140-ийн дагуу Нисэхийн аюулгүй байдлын чиглэлээр олголт – 1, сунгалт – 16:**

№	ИНД-140	Гэрчилгээ анх олгосон огноо	Гэрчилгээ сунгасан огноо	Гэрчилгээний хүчинтэй хугацаа
1	ИНҮТ	2020.04.10*	2020.04.10*	2020.12.10 2021.01.10
2	Өлгий нисэх буудал	2010.12.10	2020.04.30* 2020.10.30*	2021.04.30
3	Алтай нисэх буудал	2010.12.03	2020.06.03* 2020.12.03*	2021.06.03
4	Чойбалсан нисэх буудал	2010.10.06	2020.06.01* 2020.12.01*	2021.06.01
5	Эй Си Эйч Сервисес ХХК	2015.01.30	2020.06.19* 2020.07.22* 2020.09.12* 2020.12.12*	2021.03.12
6	Баянхонгор нисэх буудал	2010.12.08	2020.07.17* 2020.10.01*	2021.04.01
7	Мөрөн нисэх буудал	2010.11.08	2020.09.28*	2021.03.28
8	Ховд нисэх буудал	2010.09.30	2020.10.01*	2021.04.01
9	Доной нисэх буудал	2010.09.23	2020.10.14*	2021.04.15



## ИНД-171, ИНД-172, ИНД-173, ИНД-174, ИНД-175-ын гэрчилгээ сунгалт - 8, гэрчилгээ олголт - 1:

№	Агаарын навигацгийн үйлчилгээний байгууллага	Гэрчилгээний дугаар	Сунгасан огноо	Гэрчилгээний хүчинтэй хугацаа
1	Холбоо, навигац, ажиглалтын алба	171-01	2020.10.16	2021.10.16
2	Нислэгийн хөдөлгөөн үйлчилгээний алба	172-01	2020.06.10 2020.12.01	2021.12.10
3	Нислэгийн журам боловсруулалтын алба	173-01	2020.03.15 2020.09.15	2021.03.15
4	Нислэгийн цаг уурын төв	174-01	2020.03.05	2021.03.05
5	Холбоо, навигац, ажиглалтын алба	174-02	2020.08.12* /шинээр олгосон/	2021.02.12
6	Нисэхийн мэдээллийн үйлчилгээний алба	175-01	2020.06.30 2020.12.01	2023.06.01

## Үнэмлэхжүүлэлтийн талаар:

## ИНД-61 Нисгэгчийн үнэмлэх, зэрэглэлийн дагуу:

		Зэрэглэлийн хүчинтэй хугацаа сунгасан	58
Нисгэгчийн үнэмлэх, зэрэглэл эзэмшигч Нийт 135	Агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч Нийт 63	Үнэмлэх шинэчлэсэн	3
		Шинээр зэрэглэл олгосон	4
		Багшийн зэрэглэл олгосон	2
Коммерийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч Нийт 72		Зэрэглэлийн хүчинтэй хугацааг сунгасан	72
		Шинээр үнэмлэх олгосон	4
		Шинээр зэрэглэл олгосон	9

\*Гадаадын нисгэгчийн үнэмлэхийг хүлээн зөвшөөрсөн гэрчилгээ /Validation/ - 11

## ИНД-65-ын дагуу Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ажилтны үнэмлэх, зэрэглэлийн дагуу:

		Зэрэглэлийн хүчинтэй хугацаа сунгасан	158
Нислэгийн удирдагчийн үнэмлэх эзэмшигч Нийт 158		Бүсийн удирдлагын зэрэглэл шинээр олгосон	4
		Бүсийн ажиглалтын удирдлагын зэрэглэл шинээр олгосон	6
		Шинээр Аэродромын удирдлагын зэрэглэл олгосон	6
		Давхар зэрэглэл олгосон	4
Нислэгийн мэдээллийн ажилтны үнэмлэх эзэмшигч Нийт 56		Зэрэглэлийн хүчинтэй хугацаа сунгасан	55
		Сурагч Нислэгийн мэдээллийн ажилтны үнэмлэх шинээр олгосон	12
		Нислэгийн мэдээллийн ажилтны зэрэглэл шинээр олгосон	3

## ИНД-66 Агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтны үнэмлэх, зэрэглэлийн дагуу:

		Маягийн зэрэглэлийн хүчинтэй хугацаа сунгалт	131
Агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтны үнэмлэх эзэмшигч Нийт 160		Шинэ үнэмлэх олгосон	3
		Маягийн зэрэглэл шинээр олгосон	18
		Техник үйлчилгээг баталгаажуулах гэрчилгээ олгосон	10

## ИНД-67 Иргэний нисэхийн эрүүл мэндийн стандарт, гэрчилгээний дагуу:

		Эрүүл мэндийн I ангиллын гэрчилгээ	153
Эрүүл мэндийн гэрчилгээ эзэмшигч Нийт 318		Эрүүл мэндийн II ангиллын гэрчилгээ	1
		Эрүүл мэндийн III ангиллын гэрчилгээ	118



Сэтгэл зүйн шалгалтад хамрагдсан нийт - 71

СЭМҮТ-д эмийн бодисын шинжилгээнд хамруулсан – 134

**Дөрөв. Бодлогын хэрэгжилтийн чиглэлээр:**

**4.1. Агаарын зайн зохион байгуулалт, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний талаар:**

Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын агаарын навигацийн мэдээлэл дамжих зориулалт бүхий С сүлжээг бусад сүлжээнээс салгаж бие даасан сүлжээг зохион байгуулах зорилгоор нөөц шилэн кабелийг суурилуулж, цагираг сүлжээг үүсгэхэд шаардлагатай сүлжээний тоног төхөөрөмжүүдийн угсралт суурилуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

“Чингис хаан” ОУНБ-ыг агаарын навигацийн өгөгдөл дамжуулах нөөц шилэн кабелийн суурилуулалт хийхэд дэвшилтэд (CWDM) технологийг нэвтрүүлж Скайнэтворкс ХХК-тай шилэн кабел шугамын түрээсийн гэрээ байгуулан бага зардлаар тус нисэх буудлыг газар зүйн байрлалаар давхцал үүсгэхээргүй цагираг сүлжээг зохион байгуулж аюулгүй ажиллагааны түвшинг дээшлүүлж ажиллалаа.

Улаанбаатар дахь Нислэг хөдөлгөөний удирдлагын төвд COVID-19 цар тахлын халдвар илэрсэн үед Улаанбаатар бүсийн удирдлагын төвийн үйл ажиллагааг Улаанбаатар ойртолтын удирдлагын нөөц ажлын байранд шилжүүлэн ажиллах нөөц төлөвлөгөөний дагуу ойртолтын удирдлагын нөөц ажлын байранд шаардлагатай холбооны дамжуулах сүлжээг зохион байгуулж агаар-газрын дуун холбооны нөөц төхөөрөмж PAE S4 контроллеруудыг болон бусад шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг шилжүүлэн суурилуулж бүсийн удирдлагын нөөц ажлын байруудыг Агаарын навигацийн үйл ажиллагаанд ашиглахад бэлэн болсон.

Ази Номхон далайн бүсийн орнуудын агаарын навигацийн төлөвлөлт хэрэгжилтийг хангах /APANPIRG/ ажлын хэсгийн Холбоо, навигаци, ажиглалтын ажлын хэсгийн /CNS SG24/ 24 дэх нэгдсэн хуралдаан 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс 12 дугаар сарын 04-ний өдрүүдэд цахим хэлбэрээр зохион байгуулагдаж, дэлхийн 26 улс, 5 олон улсын байгууллага, 26 хамтрагч байгууллагууд нийт 176 төлөөлөгч оролцсон. Тус хурлын үеэр AIDC-Бүсийн нислэгийн хөдөлгөөн удирдлагын төвүүдийн хоорондын өгөгдлийн холбоо, CRV-Бүс нутгийн хэмжээнд өгөгдөл дамжуулах виртуал сүлжээ, SWIM -Систем даяарх мэдээллийн систем, ATN-нисэхийн цахилгаан холбооны сүлжээ, GBAS-Газар тоног төхөөрөмжид түшиглэсэн нарийвчлалыг өсгөх систем, ADS-B-Автомат хамааралтай ажиглалтын систем, Хүний хүчин зүйлс ба агаарын навигацийн инженер техникийн ажилтнууд аюулгүй ажиллагааны талаар болон бусад асуудлууд гэсэн чиглэлээр нийт 62 илтгэл /26 WP, 24 IP, 6 films/, 6 presentation/-үүд хэлэлцэгдсэн.

Үзүүлэлтэд тулгуурласан навигаци бүхий агаарын замууд тогтоох судалгааны ажил төлөвлөгөөний дагуу хийгдэж байгаа бөгөөд Монгол Улсын дээд уламжлалт агаарын замуудыг үзүүлэлтэд тулгуурласан навигаци бүхий агаарын замуудтай нэгтгэх, агаарын тээвэрлэгчид болон Олон улсын агаарын тээвэрлэгчдийн холбооноос ирүүлсэн хүсэлтийг судлах, мөн “Дэлхийн геоидын загвар EGM-08”-г иргэний нисэхэд ашиглах төлөвлөгөөний дагуу агаарын замуудын аюулгүй нам өндрийг шинэчлэн тогтоох зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

Олон улсын иргэний нисэхийн байгууллагын шаардлагаар дэлхийн улс орнуудын 5 үсгийн нэршлийн кодын давхардал, газарзүйн солбицлын зөрүү болон бусад шаардлагатай мэдээллүүдийг нэгдсэн системд бүртгүүлж, бүртгэлийг шинэчлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор 5 үсгийн нэршлийн кодын нэгдсэн сан (ICARD)-д Монгол Улсын агаарын зайд иргэний нисэхийн зориулалтаар ашиглах илтгэх цэгүүдийг шинээр болон шинэчлэн бүртгүүлэх, давхардлыг арилгах, газарзүйн солбицлын зөрүүг засварлах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийг шинээр ашиглалтад оруулах, нислэгийн хөдөлгөөний удирдлагын автомат систем (АТМ)-ийг шинээр худалдан авах гэж байгаатай холбогдуулан Монгол Улсын дээд агаарын зайн сектор зохион байгуулалтын төслийг 8-10 сектор зохион байгуулалттай байхаар судалгааны ажлыг төлөвлөлтийн дагуу гүйцэтгэж байна.

Зам, тээврийн хөгжлийн Сайдын 2019 оны 119 дүгээр тушаал “Агаарын зайг тогтоох тухай”, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 455 дугаар тогтоол, ИНЕГ-ын даргын 2020 оны А/151 тушаалын дагуу Хөшигийн хөндийд байрлах шинэ нисэх буудлын Аэродромын удирдлагын зооны босоо болон хажуугийн хэвтээ хязгаарыг шинээр тогтоож, Олон улсын нисэхийн мэдээллийн эмхтгэлээр 2020 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн Олон улсын UTC 00:00 цагаас үйл ажиллагаанд ашиглахаар зарлан мэдээлсэн.

Зам, тээврийн хөгжлийн Сайдын 2020 оны А/02 дугаар тушаал, ИНЕГ-ын даргын “Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2020 оны А/84 дүгээр тушаалын дагуу Монгол Улсын баруун бүсийн хойд хилийн солбицолд шинэ агаарын хаалга “RIPEK”-ыг 2020 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн Олон улсын 00:00 UTC цагаас нээсэн.

Нислэгийн хөдөлгөөний бүсийн удирдлагын “Төв” секторын UDA, PRING болон SERNA зэрэг цэгүүдээс ойролцоогоор 50 км-ийн радиус доторх байршлуудад 9170 метрээс 10700 метрийн өндөрт нислэг үйлдэж байсан AAR796, ABW940, GEC8407, KLM855, KAL926, KAL8535, AAR795, GEC8433 дуудлагатай агаарын





хөлгүүд Улаанбаатар, Хэнтий, Сайншанд, Булганы ADS-B станцад 2020 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 09:20 цагаас 12:30 цагийн хооронд нэгэн зэрэг ADS-B системээр илрүүлэлт хийгдээгүй. Тухайн үед Төв секторын дээр дурдагдсан байршлуудаас бусад байршилд болон өөр секторуудад нислэг үйлдэж байсан агаарын хөлгүүд дээрх ADS-B станцуудаар хэвийн илэрч байжээ. Агаарын хөлгийн экипажаас GPS –ийн дохиололд асуудал гарсан мэдээллийг “Төв” секторын Нислэгийн хөдөлгөөний удирдагчид өгсөн байсан. Дээрх үйл ажиллагаанд гарсан дутагдлын дагуу НААХЗА-ын байцаагчийн 799/20 дугаар зөвлөмж гарсан бол зөвлөмжийн дагуу холбогдох агаарын хөлгүүд, авиакомпаниудаас нөхцөл байдлын талаар мэдээлэл авч олон улсын хэмжээнд дээрх үйл ажиллагаатай холбоотой судалгааны ажлын хийлээ. Ази номхон далайн орнуудын ИКАО-ын төвийн APANPIRG/CNS-24 дүгээр хуралдаанд Евроконтролоос тавьсан илтгэлд сүүлийн 2 жилд буюу 2018, 2019 онуудад GPS сигналд дутагдал гарах тохиолдол эрс нэмэгдсэн талаар мэдээлсэн. Энэхүү нөхцөл байдалтай уялдуулан 2021 оны 6 дугаар сарын 21-ны өдрөөс ADS-B системийг нислэгийн хөдөлгөөний зайчлалд албан ёсоор ашиглахтай холбоотой GPS сигналд үүсэж буй дутагдлыг нарийвчлан, олон улсын туршлагад үндэслэн 2021 онд судалгааг өргөжүүлэхээр ажиллаж байна.

Говь-Алтай, Увс, Завхан аймгийн нисэх буудлуудад нислэгийн ярианы бичлэгийн системийг шинээр сурилуулж тоноглолыг сайжруулсан.

Доной нисэх буудалд гэрэл суултын систем, ойртолтын налуу заагч PAPI системийг ИНУТ-ийн даргын 2020 оны 07 сарын 01-ны А/113 тоот тушаалын дагуу шинээр суурилуулах ажлыг амжилттай хийж гүйцэтгэсэн. Тухайн гэрэл суултын системийг баруун дөрвөн аймгийн төслийн хүрээнд Австралийн ESDR компани 2013 онд гүйцэтгэх байсан боловч хөөрөх буух зурвасын ажлын гүйцэтгэлээс шалтгаалан хойшилж, энэ онд гэрэл суултын системийн суурилуулалтын ажлыг хийж гүйцэтгэлээ.

Агаарын навигацийн үйлчилгээний байгууламжуудын газардуулгыг сайжруулах Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын А/89 дүгээр тушаалаар Булган, Мөрөн, Дэглий цагаан, Арвайхээр, Баянхонгор, Алтай, Ховд, Өлгий, Тосонцэнгэл, Доной, Хархорин, Дорнод, Буянт-Ухаа нийт 13 нисэх буудал, Буянт-Ухаа ОУНБ-ын курс, глиссад, холын чиглүүлэх станц, ойрын чиглүүлэх станц, VOR/DME гэсэн 5 байгууламж, Төв аймгийн Мөнх-Өлзийт, Хөвсгөл аймгийн Хэнгэрэгтэй, Баянхонгор аймгийн Бөмбөгөр дэх зэрэг агаарын навигацийн байгууламж, тоног төхөөрөмжүүдийн газардуулгыг сайжруулах, шинэчлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн Булган, Мөрөн, Ховд, Баянхонгор, Алтай нисэх буудлуудад агаарын навигацийн тоног төхөөрөмжүүдийн газардуулгад аянгаас хамгаалах системийн газардуулгыг нэмэлтээр холбож аюулгүй ажиллагааны түвшинг дээшлүүлсэн. Ингэснээр агаарын навигацийн байгууламж, тоног төхөөрөмжийг гадны статик цэнэгээс хамгаалж гэнэтийн эвдрэл гэмтлийг бууруулах, найдвартай ажиллагааг хангах ажил хийгдсэн.

Сайншанд өнгөрөлтийн цэг, Өндөрхаан, Дорнод, Арвайхээр, Алтай, Ховд болон Увс нисэх буудлуудын холимог тэжээлийн системийн найдвартай ажиллагааг сайжруулах зорилгоор Transfer switch болон 3kW online UPS шинээр суурилуулалт хийгдсэн.

Иргэний нисэхийн олон улсын байгууллага /ICAO/-ын Ази-Номхон далайн бүсийн товчоо руу ЭХАТ үйл ажиллагаа явуулах чадавхийн үзүүлэлтийг (SAR Capability Matrix) харуулсан мэдээлэл болон ЭХАТ үйл ажиллагааны чадавхийн үзүүлэлт 41 үзүүлэлт бүхий (SAR PERFORMANCE INDICATORS)-ийн мэдээллийг боловсруулан 2020 оны 03 дугаар сарын 20-нд илгээсэн. Мэдээлэл хүлээн авах, дамжуулах сургууллт буюу холбооны сургууллт /communications exercise/-ыг тусгайлан боловсруулагдсан зохиомж, төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдсан. Агаарын навигацийн үйлчилгээний газрын харьяа Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны нэгжүүд болон нисэхийн үйл ажиллагаанд голлон оролцох байгууллага (ОБЕГ, ЦЕГ, ЗХ-ний АЦ)-ууд энэ арга хэмжээнд хамрагдсан.

ICAO Ази-Номхон далайн бүсийн товчооны Эрэн хайх, авран туслах үйл ажиллагааны Ажлын хэсгийн 2020 оны тайланд Монгол Улс нь Олон улсын КОСПАС-САРСАТ системээс аливаа нэг мэдээ хүлээн аваад тогтмол хариу илгээх гэж тусгагдсан байдаг бөгөөд үүний дагуу Олон улсын КОСПАС-САРСАТ системээс ЭХАТ МЗХ-ийн [ub\\_gcc@mcaa.gov.mn](mailto:ub_gcc@mcaa.gov.mn) болон АФТН-ын ZMUBYSYX хаягаар нийт 79 мэдээ (давхардсан тоогоор) ирсэн бөгөөд тэдгээрийг нягтлан шалгаад хариу мэдээг тухай бүрт нь илгээж ажилласан.

Агаарын зайн багтаамжийг нэмэгдүүлэх, ажиглалтын удирдлагын зайчлалыг ОУИНБ-ын ДОК4444-д тусгагдсан зайчлалд нийцүүлэх үүднээс ИНД75-д заагдсан тууш болон хажуугийн зайчлалыг 10км болгон багасгах судалгааг боловсруулсан.

Монгол Улсын агаарын зайн дээд агаарын замууд G218, A310, B208, B330-ыг үзүүлэлтэд тулгуурласан навигаци бүхий агаарын замууд болох Y327, Y520, Y746, Y962-тэй нэгтгэсэн төсөл боловсруулсан, мөн нийт 34 цэгийн таван үсгийн нэршлийн кодыг өөрчлөн тогтоож, 30 цэгийн таван үсгийн нэршлийн кодыг шинээр үүсгэсэн болон бусад бүсийн төвүүдээс шилжүүлэн авч ОУИНБ-ын ICARD системд бүртгүүлсэн.

Агаарын навигаци 2024 стратегийн 1.2-т заагдсан Нислэгийн хөдөлгөөний урсгалын менежментийг нэвтрүүлж, үр дүнтэй хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийн автоматжуулсан системийг нэвтрүүлэх техникийн даалгаврыг боловсруулсан бөгөөд АТФМ өгөгдлийг XML хэлбэрт шилжүүлэхэд FIXM Core 4.2.0 сүүлийн хувилбараар FF-ICE мессеж үүсгэх, дамжуулах тухай XSD дээр суурилсан зааварчилгаа өгөх 10 загварын багцыг судалж, АТФМ өгөгдлийг XML хэлбэрт шилжүүлэх, XML



өгөгдлийн бүтцийн талаар судалгаа хийгдсэн. Энэ ажлын хүрээнд Хөрш улсуудын нислэгийн хөдөлгөөний урсгал төлөвлөлтийн байгууллагуудтай хамтран ажиллах санамж бичгийн төслийг боловсруулж, ОХУ болон БНХАУ-д тус тус хүргүүлсэн. БНХАУ-аас санамж бичгийг байгуулахаар зөвшөөрсөн ба ОХУ-ын талаас хариу ирээгүй тул ИНЕГ-ын 2020 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 07/64 тоот албан бичгээр, мөн Зам, тээврийн хөгжлийн дэд сайдын айлчлалын үеэр ОХУ-ын талаас санамж бичиг байгуулах ажилд хариу ирүүлэхийг хүссэн боловч COVID-19 цар тахлаас шалтгаалан хариу ирүүлээгүй байна.

Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлогын 1.2.4 дэх “Иргэний нисэхийн үйлчилгээнд олон улсын стандарт, шаардлагад нийцсэн аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан, орчин үеийн дэвшилтэт техник, технологийн шинэчлэлтийг тогтмол хийх” ажлын хүрээнд Иргэний нисэхийн үндэсний төв нь Олон улсын агаарын навигацийн үйлчилгээний байгууллага /CANSO/-тай 2020 оны 7 дугаар сарын 06-ны өдөр гэрээ байгуулан “HORIZON” программыг туршилтаар ашиглаж байна.

2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар нийт 338779 нислэг төлөвлөгдөж 74365 нислэг гүйцэтгэгдсэн. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс нийт 69367 нислэг буюу 48.3%-иар буусан байна. Үүнд:

- Олон улсын өнгөрөлт-59228 буюу 46.8%
- Олон улсын хөөрөлт, буулт-7984 буюу 82.9%
- Орон нутгийн хөөрөлт, буулт-2155 буюу 28.3% тус тус буурчээ.

Хуваарьт нислэг 54647 гүйцэтгэгдсэн. Үүнд:

- Хуваарьт өнгөрөлт-50921 буюу 57%
- Хуваарьт олон улсын хөөрөлт, буулт-1159 буюу 85.4%
- Хуваарьт орон нутгийн хөөрөлт, буулт-2567 буюу 20.6%-иар тус тус буурчээ.

Олон улсын болон орон нутгийн цагийн хуваарийн бус нийт 19718 нислэг гүйцэтгэгдсэн. Үүнд:

- Хуваарьт бус өнгөрөлт-16345 буюу 103%-иар өссөн,
- Хуваарьт бус олон улсын хөөрөлт, буулт-487 буюу 71.5%-иар буурсан,
- Хуваарьт бус орон нутаг-2886 буюу 34%-иар буурсан байна.

Дэлхий дахинд COVID-19 цар тахал тархсантай холбоотой улс орнууд агаарын хилээ хаасан нь Европ болон Ази-Номхон далайн бүсийн орнуудыг чиглэсэн Монгол Улсын агаарын зайгаар дамжин өнгөрөх нислэгүүд буурсан. Мөн Засгийн газар болон УОК-ийн шийдвэрээр хуваарьт нислэгүүдийг зогсоосон, хөл хорио тогтоосны улмаас олон улсын хөөрөлт буултын нислэг болон орон нутгийн нислэгүүд буурсан байна. Монгол Улсын агаарын зайд 2020 онд нийт 104 агаарын тээвэрлэгч нислэг гүйцэтгэсэн байна.

#### **4.2 Нисэхийн мэдээлийн үйлчилгээний талаар:**

Эрх бүхий томилогдсон мэдээлэгчдээс ирүүлсэн эх өгөгдлийг үндэслэн NOTAM мэдээг боловсруулах үйл ажиллагааг холбогдох дүрэм, журам, зааврын дагуу явуулж AFTN сүлжээ, электрон шуудан, 2D, 3D хэлбэр болон албаны веб сайтаар дамжуулан хэрэглэгчдийг NOTAM мэдээ, цасны NOTAM мэдээгээр шуурхай хангаж ажилласан. Мөн аэродромын нислэгийн хөдөлгөөний мэдээ зохицуулалтын үйлчилгээний хүрээнд нислэгийн хөдөлгөөний мэдээнүүдийг боловсруулж гадаад, дотоодын хэрэглэгч байгууллагуудыг хангаж ажилласан. Үүнд:

/2020.12.31-ний байдлаар/

Хамаарах хэсэг		Утга		Бүгд
НШМХ	Олон улсаас хүлээн авсан нийт NOTAM мэдээ			444785
	Чухал ач холбогдолтой NOTAM мэдээ			720
	Зарласан NOTAM мэдээ	А сери		829
		С сери		469
		SNOWTAM		-
	Боловсруулсан	2D график NOTAM мэдээ		581
		3D график NOTAM мэдээ		157
		Олон улсын чиглэл	НӨМҮ	1059
		Орон нутгийн чиглэл		2703
	НШМХ	АФТН	Олон улсаас Буянт-Ухаад	Нислэгийн төлөвлөгөө
Хөөрөлт				787
Буулт				799
Буянт-Ухаагаас олон улсад			Нислэгийн төлөвлөгөө	821
			Хөөрөлт	761
			Буулт	837
Орон нутгаас Буянт-Ухаад		Нислэгийн төлөвлөгөө	2431	
		Хөөрөлт	2407	
		Буулт	2431	
Буянт-Ухаагаас орон нутагт		Нислэгийн төлөвлөгөө	2519	
		Хөөрөлт	2488	
		Буулт	2504	



НШМХ	Цахим хуудсанд оруулсан нийт NOTAM мэдээ	1151
	Боловсруулсан шуурхай мэдээ	1936
	Цахим хуудсанд оруулсан шуурхай мэдээний нийт тоо	1887

Олон улсын чиглэлд 4057, орон нутгийн чиглэлд 3392 нислэгт нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээ үзүүлсэн.

#### **4.3. Холбоо навигац, ажиглалтын үйлчилгээний чиглэлээр:**

Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал дахь Нислэгийн хөдөлгөөн удирдлагын цамагт суурилуулсан тооцоот ажиглалтын автоматжуулсан систем (Si-ATM)-ийг нисэхийн суурин холбооны (AFTN) сервертэй холбож турших, нислэгийн удирдлагын функцийг шалгах ажлыг Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын А/05 дугаар тушаалаар хийж гүйцэтгэсэн.

Агаарын навигацийн тоног төхөөрөмжүүдийн цахилгаан тэжээлийн найдвартай байдлыг дээшлүүлэх зорилгоор Нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийн цахилгаан хангалтын схемийн өөрчлөлтийг Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2020 оны А/11 дүгээр тушаалын дагуу хийж гүйцэтгэсэн.

Автомат хамааралтай ажиглалтын систем (ADS-B)-ийн газрын станцуудын хэвийн найдвартай ажиллагааг сайжруулах зорилгоор Дорнод аймгийн Чойбалсан хот, Булган аймгийн Булган сум, Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Их-Өлгий дэх радиолокаторын байгууламж, Завхан аймгийн Ургамал сум, Баянхонгор аймгийн Бөмбөгөр сум, Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын Баянтээг радиолокаторын байгууламж дахь газрын станцуудын антены байгууламжийг өргөтгөж, ИНЕГ/ХО/ТББ/Б-16/19 тоот гэрээт ажлын хүрээнд нийлүүлэгдсэн эд ангийг суурилуулах туршилт, шалгалтын ажлыг Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2020 оны А/88 дугаар тушаалын дагуу хийж гүйцэтгэсэн.

Улаанбаатар нислэгийн хөдөлгөөн удирдлагын төвийн автоматжуулалтын систем /AIRCON2100/-ийг БНХАУ-ын Бээжин нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвтэй /AIDC/ тоон өгөгдлийн холбоогоор холбон турших, нислэгийн удирдлагын функцийг шалгах ажлыг Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2020 оны А/76 дугаар тушаалын дагуу хийж гүйцэтгэсэн.

Агаар-газрын холбооны дуун холболтын /GAREX/ системийн нөөц төхөөрөмж /PAE S4/ контроллерын бичлэгийн системийн техникийн шийдлийг гаргаж (4800 AUD) бага зардлаар IP60 суваг бичих боломжтой TRVR-VS+V60-LinX Virtualis програм хангамжийг ИНХТ-ийн даргын А/153 дугаар тушаалын дагуу суурилуулж бүрэн ажиллагаанд оруулан тоноглолыг сайжруулсан

#### **4.4. Шалгалтын нислэгийн чиглэлээр:**

Орон нутгийн нисэх буудлуудад суурилуулсан нийт 12 гэрэл суултын систем, 10 ойртолтын налуу заагч PAPI системийг Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын баталсан хуваарьт төлөвлөгөөний дагуу фотометрийн хэмжилт, баталгаажуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Мөн дээрх батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан “Чингис хаан” болон “Буянт-Ухаа” олон улсын нисэх буудлуудын хэрэглэлээр оролт үйлдэх систем буюу ILS/DME системд хийх ээлжит нислэгээр шалган баталгаажуулах ажлыг цар тахлын нөхцөл байдал болон ашиглагдаж байсан АТ-920 төхөөрөмжийн ашиглалтын хугацаа дууссантай холбоотой 2020 онд гүйцэтгэх боломжгүй нөхцөл байдал үүссэн. Тус нисэх буудлуудын ILS/DME системд хийх ээлжит нислэгээр шалган баталгаажуулах ажлыг БНХАУ-ын иргэний нисэхийн асуудал эрхэлсэн байгууллагын харьяа Шалгалтын нислэгийн төвөөр гүйцэтгүүлэхээр төлөвлөн гэрээ байгуулах, цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан гүйцэтгэхээр төлөвлөн ажилласан ч гэрээ байгуулагдаагүй шалтгаанаар тус ажлыг гүйцэтгэх боломжгүй нөхцөл үүссэн. Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нислэгээр шалган баталгаажуулах багаж хэрэгслийг тусган оруулсны дагуу АТ-940 төхөөрөмжийг худалдан авах ажиллагааг амжилттай зохион байгуулж, хүлээн авах ажил хийгдэж байна. Цаашид тус төхөөрөмжийг ашиглан дээрх нисэх буудлуудын ILS/DME төхөөрөмжийг нислэгээр шалган баталгаажуулах ажлыг гүйцэтгэхээр төлөвлөн ажиллаж байна.

#### **4.5. Оношлогоо, хэмжил зүй лабораторийн талаар:**

“Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль”-ын дагуу “Хэмжил зүйн болон газрын тосны сорилтын лаборатори итгэмжлэлийн техникийн хороо”-ны хуралдааны шийдвэрийг үндэслэн Стандарт хэмжил зүйн газрын даргын 2019 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн А/239 тоот тушаалаар 4 жилийн хугацаатай 6 дахь удаагаа итгэмжлэгдсэн. Энэ удаагийн итгэмжлэл нь “Геодезийн захиалагчийн хяналтын хэмжилт”, “Хуйларсан гүйдлийн сорил”-ын төрлүүдээр механик хэмжилт, сорилт гүйцэтгэх техникийн чадавхтайгаа нотлон итгэмжлэлийн хүрээгээ өргөтгөснөөрөө онцлог байсан.

Захиалагч байгууллагын хүсэлтийн дагуу газрын тосны бүтээгдэхүүний 228 дээжид чанар хяналтын иж бүрэн шинжилгээ хийж, үр дүнг боловсруулан хүргүүлсэн.

Төвийн болон орон нутгийн нисэх буудлуудын 34 цаг уурын автомат станц, 4 даралт хэмжигч, 2 чийг температур хэмжигчид хэмжилт, шалгалт тохируулга хийж гүйцэтгэсэн.



Радио, цахилгааны 58 хэмжих хэрэгсэлд хэмжилт, шалгалт тохируулгын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Төвийн болон орон нутгийн нисэх буудал, радио локаторийн байгууламж, өнгөрөлтийн цэгийн тоног төхөөрөмж, түлш нөөцлөх сав, аянга зайлуулагч, барилга байгууламжийн 538 газардуулгын эсэргүүцлийн хэмжилтийг хийж гүйцэтгэсэн.

Орон нутгийн 15 нисэх буудлуудын 41 түлш нөөцлөх савны хазайлтын хэмжилтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.

Төвийн болон орон нутгийн нисэх буудлуудад ашиглагдаж байгаа 17 сүмбэнметрийн шалгалт тохируулгын ажлыг хийж гүйцэтгэсэн.

“Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудалд геодезийн захиалагчийн хяналтын 4 удаа хэмжилт, “Чингис хаан” Олон улсын нисэх буудалд дараах геодезийн захиалагчийн хяналтын 14 хэмжилтийг тус тус хийж гүйцэтгэсэн.

“Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор”-ын гадна хелипортын талбай, Гэмтэл согог судлалын үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн төв, Наадам центр хажууд “Саксерр райдер” ХХК барилга дээр хелипортын талбай, Канад улсын элчин сайдын яамны хелипортын талбай дээр геодезийн хяналтын хэмжилт хийсэн.

Газрын тусгай үйлчилгээ шатахуун хангалтын албаны авто тээврийн хэрэгсэл байршуулдаг гараашийн цемент бетон шалны геодезийн хяналтын хэмжилтүүдийг гүйцэтгэж үр дүнгийн хуудсыг боловсруулан захиалагчид хүргүүлсэн.

Орон нутгийн 4 нисэх буудлын түлш нөөцлөх 10 ш савны насжилтыг тодорхойлж, үл эвдэх сорилын үзлэг шалгалтыг хийж гүйцэтгэж, үр дүнг боловсруулан тусын нисэх буудлууд болон Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албанд хүргүүлсэн.

Дарханы төмөрлөгийн үйлдвэр хувьцаат компанийн Улаанбаатар дахь Төмөр бэлтгэх төвийн КК-20/32 маркийн вандан краны хөшүү хөлөнд үл эвдэх сорилын үзлэг шалгалт хийж, үр дүнг боловсруулан хүргүүлсэн.

Булган болон Мөрөн нисэх буудлуудад ашиглагдаж байгаа Газрын тосны бүтээгдэхүүн нөөцлөх савны гаралт болон оролтын шугам хоолойн холболтуудын гагнуурын оёдлуудад үзлэг шалгалт, хэмжилт гүйцэтгэж, үр дүнг боловсруулан хүргүүлсэн.

2020 онд түлш нөөцлөх 5 саванд үл эвдэх сорилын үзлэг шалгалт хийхээр төлөвлөснөөс 10 саванд үл эвдэх сорилын үзлэг шалгалт хийж гүйцэтгэсэн.

Сорилт шинжилгээний хэсгийн 20 тоног төхөөрөмжид батлагдсан хуваарийн дагуу 40 удаа, төлөвлөгөөт бус 12 удаа техник үйлчилгээ хийгдсэн.

Хэмжил зүйн хэсгийн 20 төрлийн хэмжих хэрэгсэлд батлагдсан хуваарийн дагуу 63 удаа техник үйлчилгээ хийсэн.

Монголын ашигт малтмал газрын тосны лабораториудын нэгдсэн холбооноос зохион байгуулсан лабораторийн шинжилгээний үнэн зөв байдлыг үнэлэх лаборатори хоорондын харьцуулалтад ТС-1 түлш, дизелийн түлш, бензин, хөдөлгүүрийн тос гэсэн 4 төрлөөр амжилттай оролцсон.

2019 онд захиалагч байгууллагын хүсэлтээр газрын тосны бүтээгдэхүүний 312 дээжид чанар, хяналтын иж бүрэн шинжилгээ хийсэн. Орон нутгийн нисэх буудлаас ирүүлсэн 20 дээжинд сорилт шинжилгээ хийж гүйцэтгэхээс ТС-1 түлшний 25 дээжинд шинжилгээ хийсэн.

Хувийн 3 нисэх буудал, төвийн болон орон нутгийн 18 нисэх буудал, 6 радио локаторийн байгууламж, 3 өнгөрөлтийн цэг болон хувийн нэг компанийн тоног төхөөрөмж, шатахуун нөөцлөх сав, аянга зайлуулагч, барилга байгууламжийн 532 газардуулгын эсэргүүцлийн хэмжилтийг хийж гүйцэтгэсэн.

Төвийн болон орон нутгийн нисэх буудлуудын 34 цаг уурын автомат станцын хэмжилт, шалгалт тохируулгын ажлыг хийж гүйцэтгэсэн. Захиалгын дагуу дараах радио цахилгааны 51 хэмжих хэрэгслийн хэмжилт, шалгалт тохируулгын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Захиалагч байгууллагаас ирүүлсэн захиалгын тоо, хэмжээгээр геодезийн хяналтын хэмжилт хийж гүйцэтгэсэн. Орон нутгийн нисэх буудлуудын газрын тосны бүтээгдэхүүн нөөцлөх 39 савны хазайлтыг хэмжиж, 16 сүмбэнметрийн шалгалт тохируулгыг хийж гүйцэтгэсэн.

#### **4.6. Нисэх бүүдлын үйлчилгээний талаар:**

Нисэх бүүдлын үйлчилгээ /иргэний нисэхийн аюулгүй байдал, аэродром/-ний бодлогын хэрэгжилтийг хангах, иргэний нисэхийн багц дүрмийн шаардлагыг хангах, хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангах, аюулгүй ажиллагааны тогтолцоог хэрэгжүүлэх, нисэх бүүдлуудын агаарын тээвэрлэлтийн үйл ажиллагааны эдийн засгийн үзүүлэлтэд судалгаа шинжилгээг хийх, олон улсын болон орон нутгийн нисэх бүүдлуудын үйл ажиллагааны талаар холбогдох байгууллагыг мэдээллээр хангах чиг үүрэгтэйгээр ажиллаж байна.

Иргэний нисэхийн ерөнхий газар болон түүний салбар нэгжийн 2020-2021 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөг 2020 оны 7 дугаар 16-ны өдөр батлуулж, 2020 оны 7 дугаар сарын 22-ны өдөр Зам тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн. Төлөвлөгөөний хэрэгжилтийг 7 хоног бүр салбар нэгжүүдээс авч нэгтгэн дүгнэж, сар бүрийн 25-ны өдөр Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлж ажилласан. Иргэний нисэхийн ерөнхий газар болон түүний салбар, нэгжийн 2020-2021 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөө 100% хэрэгжиж, тайланг 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдөр Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн.

*Агаарын тээврийг хялбаршуулах Үндэсний хөтөлбөр:* Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 289 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хөтөлбөрийг шинээр боловсруулан батлуулах талаар зөвлөмж өгсөн. Тус хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг ИНЕГ-ын даргын 2020 оны А/100 дугаар



тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг бодлогын баримт бичгийг боловсруулах үндэслэл, тулгамдаж байгаа асуудал, мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн. Чикагогийн конвенцийн 9 дүгээр хавсралтад орсон 27 дугаар нэмэлт, өөрчлөлтийг орчуулж, ХЗДХЯ, ГХЯ-д хүргүүлэн орчуулгыг баталгаажуулсан. Хөтөлбөрийн төслийг боловсруулж, баталгаажуулахаар ИНЕГ-ын дэд даргын 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 02/2816 тоот албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн.

Агаарын тээврийг хялбаршуулах зөвлөлийн дэргэдэх Нарийн бичгийн даргын ажлын албаны ээлжит хурлыг 2020 оны 3 дугаар сарын 17-ны өдөр, 7 дугаар сарын 07-ны өдөр тус тус зохион байгуулсан.

Агаарын тээврийг хялбаршуулах зөвлөлийн ээлжит 7 дугаар хурлыг Зам, тээврийн хөгжлийн яаманд 2020 оны 10 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулж 2 багц 10 шийдвэр гарсныг Зөвлөлүүдийн гишүүн байгууллагуудад хүргүүлэн ажилласан.

Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 96%, Агаарын тээврийг хялбаршуулах зөвлөлийн батлагдсан төлөвлөгөөний биелэлт 78%-ийн гүйцэтгэлтэй байна.

*Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр:* Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 175 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 2018, 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тус хөтөлбөрийг шинээр боловсруулан батлуулах талаар зөвлөмж өгсөн. Дээрх зөвлөмж болон 2020 оны 7 дугаар сарын 30-ны өдрөөс олон улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн “Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенци”-ийн Хавсралт 17-ийн 17 дахь нэмэлт өөрчлөлттэй нийцүүлэн “Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр”-ийг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2020 оны А/100 дугаар тушаалаар байгуулсан. Хөтөлбөрийн төслийг боловсруулж, баталгаажуулахаар Иргэний нисэхийн ерөнхий газрын дэд даргын 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 02/2816 тоот албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн.

Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн дэргэдэх Нарийн бичгийн даргын ажлын албаны ээлжит хурлыг 2020 онд 3 дугаар сарын 17-ны өдөр, 7 дугаар сарын 07-ны өдрүүдэд 2 удаа зохион байгуулсан.

Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн ээлжит 15 дугаар хурлыг Зам, тээврийн хөгжлийн яаманд 2020 оны 10 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулж тус хурлаас 3 багц, 11 шийдвэр гарсныг Зөвлөлүүдийн гишүүн байгууллагуудад хүргүүлж ажилласан.

Иргэний нисэхийн Аюулгүй байдлын зөвлөлийн 2020 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн хурлаар Коронавируст халдварын үед нислэг эргэн сэргэхэд нисэх буудлын бэлэн байдлыг шалгах Эрсдэлийн үнэлгээ хийх шийдвэрийн дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2020 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн А/366 тоот тушаалаар “Олон улсын нислэг сэргээх, нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбогдуулан олон улсын нисэх буудлуудад бэлэн байдлыг шалгах” ажлын хэсэг байгуулсан. Тус ажлын хэсэг нь “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудал, “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын бэлэн байдлыг шалгах хуудсыг чиглэл тус бүрээр хамтран боловсруулж, эрсдэлийн үнэлгээ хийж тайланг гаргасан.

Хөтөлбөрийн хэрэгжилт 2020 онд 95%, Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн батлагдсан төлөвлөгөөний биелэлт 70%-ийн гүйцэтгэлтэй байна.

*Агаарын хөлөг шувуу, мал амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх хөтөлбөр:* Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх зөвлөлийн 2019 оны хурлаас гаргасан зөвлөмжийг холбогдох 31 байгууллагад Иргэний нисэхийн ерөнхий газрын 2020 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 01/191 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх зөвлөлийн дэргэдэх Нарийн бичгийн даргын ажлын албаны хурлыг 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Иргэний нисэхийн ерөнхий газарт зохион байгуулсан.

“Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх орон нутгийн салбар зөвлөл”-ийг мэргэжлийн зөвлөгөөгөөр хангаж, орон нутгийн 9 нисэх буудлын хурлыг зохион байгуулсан.

Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх зөвлөлийн дэргэдэх Нарийн бичгийн даргын ажлын албыг Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2020 оны А/447 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар Нарийн бичгийн даргын ажлын албаны ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар шинэчлэн баталсан.

Зам тээврийн хөгжлийн Сайдын 2016 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 48 дугаар тушаалаар баталсан “Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх хөтөлбөр (2016-2021)”-ийн хэрэгжилт 95.5%, агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх зөвлөлийн батлагдсан төлөвлөгөөний биелэлт 68.5% байна.

*Олон улсын иргэний нисэхийн байгууллагын зарим стандартыг үндэсний стандарт болгон нутагшуулах ажлын хүрээнд:* “Аэродромын төлөвлөлт ба ашиглалтын норм ба дүрэм”-ийг Зам, тээврийн салбарын шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 7 дугаар хурлаар хэлэлцүүлж, батлуулах шийдвэр гаргуулсан. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн А/132 дугаар тушаалаар “Аэродромын төлөвлөлт ба ашиглалт” техникийн баримт бичиг батлагдсан.





Агаарын хөлгийн гадаргууг мөстөлтөөс хамгаалах үйл ажиллагаатай холбоотой 4 ширхэг Олон улсын SAE AS стандартуудын худалдан авалтыг хийсэн. Үүнд:

- ✓ AS 6286 "Aircraft Ground Deicing/Anti-Icicing Training and Qualification Program"
- ✓ AS 6332 "Aircraft Ground Deicing/Anti-Icicing Quality Management"
- ✓ ARP 6257 "Aircraft Ground Deicing/Anti-Icicing Communication Phraseology"
- ✓ AS 6285 "Aircraft Ground Deicing/Anti-Icicing Processes"

Стандартуудын орчуулгыг "Шинэ үндис" ХХК-иар хийлгэж, 2020 оны 6 дугаар сард хүлээн авсан. "Агаарын хөлгийн гадаргууг мөстөлтөөс хамгаалах болон гадаргууд тогтсон цас, мөсийг арилгах зориулалт бүхий тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны заавар"-т нэмэлт өөрчлөлтийг оруулж байна.

"Агаарын хөлгийн шатахууны чанарын хяналт ба нисэх буудлын дэргэдэх шатахууны агуулах болон гидрант системийн үйл ажиллагаанд тавих шаардлага" стандартыг орчуулж, төслийг боловсруулан, санал авахаар ЗТХЯ, ЭХЯ, УУХҮЯ, МХГ, НААХЗА, Агаарын тээвэрлэгчид, "Нью улаанбаатар интернэйшнл эйрпорт" ХХК зэрэг байгууллагуудад Иргэний нисэхийн ерөнхий газрын 2020 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 01/1532 тоот албан бичгээр хүргүүлж саналыг нэгтгэж, стандартад дахин нэмэлт өөрчлөлт оруулахаар ажиллах явцад стандартыг Англи улсаас бүрэн эхээр нь худалдан авах шаардлагатай болсон тул стандартын эрх эзэмшигч байгууллагаас нэхэмжлэхийг хүлээн авч, худалдан авах ажиллагааг хийж байна.

Зам, тээврийн сайдын 2016 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 48 дугаар тушаалаар баталсан "Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх хөтөлбөр"-ийн 7.1.2-т Аэродромын шувуу, мал, амьтдыг хянах үйл ажиллагааны стандарт боловсруулж, батлуулахаар тусгагдсаны дагуу "Аэродром орчмын шувуу, мал, амьтдыг хянах үйл ажиллагааны стандарт"-ыг шинээр боловсруулан, НААХЗА болон Агаарын хөлгийн шувуу, мал амтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх зөвлөлийн гишүүн байгууллагуудын ирүүлсэн саналыг тусган Стандарт хэмжилзүйн газрын хурлаар хэлэлцүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

*Нисэх буудлуудын хөгжлийн талаар:* "Нисэх буудлуудыг 2045 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөө" боловсруулахад ашиглагдах баримт бичгүүдийг нэгтгэж, судалгаа хийгдсэний дагуу Мастер төлөвлөгөөнд агаарын навигацийн тоног төхөөрөмжийн төлөвлөгөөг нэмж тусгасан. Мөн Аэродром, навигацийн мастер төлөвлөгөөний 3D зураг боловсруулж байна.

"Олон улсын нисэх буудлуудын нэрийг өөрчлөх, тэдгээрийн ашиглалтын талаар авах арга хэмжээний тухай" Засгийн газрын 2019 оны 455 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан "Буянт Ухаа" Олон улсын нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэх нэгдсэн төлөвлөгөө"-г боловсруулан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн А/55 дугаар тушаалаар батлуулсан. Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2020 оны 5 дугаар сарын 11-ний А/283 дугаар тушаалаар "Буянт Ухаа" ОУНБ-ын үйл ажиллагааг эхлүүлэх нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хэсэг байгуулсан. Нисэх буудлын үйл ажиллагаанд 2020 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд шаардагдах төсвийн төслийг боловсруулж, Иргэний нисэхийн ерөнхий газрын 2020 оны төсөвт тусган батлуулсан.

*Аэродромын үйл ажиллагааны чиглэлээр:* Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны "Зөвлөмж:20091028"-ын дагуу Ховд аймгийн "Ховд" нисэх буудлын аэродромын хучилттай элементүүдийн даацын тооцооллыг техникийн аргаар тодорхойлох ажлын хүрээнд Геотехникийн судалгааны ажлын тайлан боловсруулах эрх бүхий байгууллагаар орон нутгийн 7 нисэх буудлын судалгааг хийлгэж, тооцооллыг "СОМГАА" программаар хийж, нисэхийн мэдээллийн эмхэтгэлээр зарлуулах ажил хийгдэж байна. Үүнээс Ховд" нисэх буудлын аэродромын хучилттай элементүүдийн даацын техникийн аргаар тодорхойлж, Нисэхийн мэдээллийн эмхэтгэлээр шинэчлэн зарлуулсан.

Орон нутгийн нисэх буудлуудын аэродромын засвар арчлалтын ажлын хэмжээг тодорхойлж, "Гурвансайхан" нисэх буудлын аэродромын хучилттай элементүүдийн урсгал засвар, "Тосонцэнгэл" нисэх буудлын аэродромын их засварын ажлыг гүйцэтгүүлсэн.

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2020 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн А/298 дугаар тушаалаар батлагдсан Аж ахуй нэгж, байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу аэродром, хэлипорт байгуулах ажлуудад хамтран ажиллаж байна. Мөн авиа компанийн захиалгын дагуу 2020 онд 37 хээрийн түр зурвас талбай сонгосон байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/992 дугаар тушаалаар батлагдсан "Хязгаарлагдмал аэродромын гэрчилгээ эзэмших нисэх буудлуудын жишиг "Аэродромын ерөнхий заавар"-ыг боловсруулж, холбогдох орон нутгийн нисэх буудлуудад хүргүүлсэн.

"Түр зурвас, талбай сонгох, бүртгэх журам"-ыг боловсруулж, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн А/270 дугаар тушаалаар батлуулсан бөгөөд Захиргааны ерөнхий хуулийн 65 дугаар зүйлд заасны дагуу улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлээгүйгээс нийтээр дагаж мөрдөх баримт бичиг болоогүй болон агаарын тээвэрлэгч байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу шинэчлэн боловсруулж, батлуулахаар тушаалын төсөлд санал авч, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргад хүргүүлсэн.

*Аюулгүй байдлын хөтөлбөрийн хүрээнд:* "Иргэний нисэхийн аюулгүйн үзлэгийн ажилтан болон зааварлагчийг үнэмлэхжүүлэх журам"-ыг боловсруулж, ИНЕГ-ын даргын 2020 оны 5 дугаар сарын 04-ний А/275 дугаар тушаалаар, "Буянт-Ухаа" Олон улсын нисэх буудлын "Аюулгүй байдлын хөтөлбөр"-ийг боловсруулж, ИНЕГ-ын даргын 2020 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн А/331 дүгээр тушаалаар тус тус баталсан.

Өлгий, Алтай, Баянхонгор, Гурвансайхан, Чойбалсан, Дэглий цагаан, Мөрөн нисэх буудлуудын "Аюулгүй байдлын хөтөлбөр"-үүдэд нэмэлт өөрчлөлтийг оруулсан.

"Чингис хаан" ОУНБ-ын аюулгүйн үзлэг шалгалт, аюулгүйн хамгаалалтын үйлчилгээг ИНД-140-ийн дагуу гэрчилгээжсэн байгууллагаар гүйцэтгүүлэх аюулгүй байдлын үйлчилгээ үзүүлэх гэрээний нөхцөл, тарифыг "Нью



Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” ХХК-тай хэлэлцэж, 2021 оны 6 дугаар сарын 15-ны өдрөөс аюулгүйн хамгаалалтын үйлчилгээг цогцоор нь үзүүлэхээр тохиролцсон.

*Аюулгүйн хамгаалалтын үйл ажиллагааны чиглэлээр:* Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 455 дугаар тогтоолын дагуу Олон улсын нисэх буудлуудын нэрийг өөрчлөхтэй холбогдуулан Иргэний нисэхийн үндэсний төвийн Аюулгүйн хамгаалалтын ерөнхий зааварт нэмэлт өөрчлөлтийг 2020 оны 6 дугаар сарын 17-ны өдөр оруулсан.

Гэрээт харуул хамгаалалтын сургалтад хамрагдах Аюулгүй байдал, хамгаалалтын алба болон орон нутгийн нисэх буудлуудын аюулгүйн хамгаалалтын нийт 47 ажилтныг Дотоод хэргийн их сургуульд 21 хоногийн сургалтад хамруулан үнэмлэхжүүлэх ажлыг зохион байгуулсан.

Аюулгүй байдал, хамгаалалтын алба болон орон нутгийн нисэх буудлуудын нисэхийн аюулгүйн хамгаалалтын нийт 28 ажилтныг Иргэний нисэхийн аюулгүй байдлын суурь сургалт /Basic 123/-д хамруулан мэргэжлийн үнэмлэхжүүлэх ажлыг зохион байгуулсан.

*Тээвэр зохион байгуулалт, зорчигч үйлчилгээний чиглэлээр:* Агаарын тээврийг хялбаршуулах Зөвлөлийн 2020 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн хурлаар “Коронавируст халдварын үед нислэг эргэн сэргэхэд нисэх буудлын бэлэн байдлыг шалгах Эрсдэлийн үнэлгээ хийх” шийдвэрийн дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2020 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн А/366 тоот тушаалаар байгуулсан ажлын хэсэг нь “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудал, “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын бэлэн байдлыг шалгах хуудсыг чиглэл тус бүрээр Хилийн хяналтын байгууллагуудтай хамтран боловсруулж, эрсдэлийн үнэлгээ хийж, тайланг нэгтгэсэн.

SITA компанийн APIS-ын 2007 онд байгуулсан гэрээний нэмэлт өөрчлөлтийг хянаж, 2020 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр Иргэний нисэхийн ерөнхий газар болон SITA компанийн 2 талын гарын үсгийг цахимаар зуруулж баталгаажуулсан. Гэрээний нэмэлт өөрчлөлт баталгаажсанаар цаашид олон улсын зорчигчдын урьдчилсан мэдээлэл тасрах эрсдэлгүй, APP хэрэгжин ажиллаж байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын “Цагийн хуваарийн зөвлөл”-ийн 01 дүгээр хурлыг 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр зохион байгуулж, олон улсын болон орон нутгийн 2020 оны зуны тогтмол нислэгийн цагийн хуваарийг баталсан. Батлагдсан цагийн хуваарийн хугацаанд Улсын онцгой комиссын “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх” шийдвэрийн дагуу олон улсын нислэгийн цагийн хуваарьт 10 удаагийн цуцалсан өөрчлөлтийг оруулж Зөвлөлөөр батлуулсан.

Иргэний нисэхийн ерөнхий газрын Цагийн хуваарийн зөвлөлийн 2 дугаар хурлыг 2020 оны 6 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулж, 7 шийдвэр гарсан. Хэрэгжилт 100%-тай дүгнэгдсэн.

Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 227 дугаар тогтоол ба Улсын онцгой комиссын шийдвэрийн дагуу “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын үйл ажиллагааг 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэл тасралтгүй хэвийн үргэлжлүүлэхтэй холбогдуулан орон нутгийн зуны тогтмол нислэгийн цагийн хуваарьт 6 удаагийн өөрчлөлтийг оруулж Зөвлөлөөр батлуулсан.

Цагийн хуваарийн зөвлөлийн 3 дугаар хурлыг 2020 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр зохион байгуулж, 2020-2021 оны олон улсын болон орон нутгийн өвлийн тогтмол нислэгийн цагийн хуваарийг хэлэлцэж баталсан. Улсын онцгой комиссийн шийдвэрийн дагуу олон улсын тогтмол нислэгийн цагийн хуваарийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал цуцалж, Цагийн хуваарийн зөвлөлөөр батлуулсан.

*Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт:* Хэнтий аймгийн “Дэлүүнболдог” нисэх буудлын ЗС ангиллын хөөрч буух зурвас байгуулах судалгааг гүйцэтгэн, нисэх буудлын техникийн нөхцөлүүдийг тодорхойлон, үнэлгээний хороонд тендер зарлуулахаар 2020 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр цахимаар хүргүүлсэн. Тус нисэх буудлыг Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ICAO/-ын стандартын дагуу ЗС хяналтын код бүхий хучилттай аэродром болгож, хүчин чадлыг нэмэгдүүлэх төслийн үйл явцын танилцуулгыг бэлтгэсэн.

Өндөрхаан нисэх буудлыг шинэчлэн барих төслийн Багц –1 буюу аэродромыг шинэчлэн барих ажлыг 2020 оны 3 дугаар сарын 27-ны өдөр тендерийн үнэлгээний хорооноос Зам, тээврийн хөгжлийн яаманд шууд гэрээ байгуулах зөвшөөрөл олгосон. Өндөрхаан нисэх буудлыг шинэчлэн барих төслийн Багц-2 буюу зорчигч үйлчилгээний цогцолборын барилгын нээлттэй сонгон шалгаруулалтын ажлыг 2020 оны 5 дугаар сарын 26-нд нээсэн.

Увс аймгийн “Дэглий цагаан” нисэх буудлын аэродром болон зорчигч үйлчилгээний барилгыг өргөтгөх ажлын зорилтын хүрээнд, тус нисэх буудлын зорчигч үйлчилгээний цогцолбор, цагт 300 зорчигчид үйлчлэх хүчин чадалтай болгон өргөтгөх ажлын зураг төсөл, төсвийг боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын тендерийг 2020 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр зарласан. Нээлттэй сонгон шалгаруулалтад 3 компани оролцсон бөгөөд 2020 оны 5 дугаар сарын 21-ний өдөр нээсэн.

Дорнод аймгийн “Чойбалсан” нисэх буудлыг Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ICAO/-ын стандарт шаардлагыг хангасан 4С ангилал бүхий хөөрч буух зурвас, зорчигч үйлчилгээний цогцолбор олон улсын нисэх буудал байгуулах төслийн танилцуулгыг бэлтгэсэн бөгөөд тус нисэх буудлын барилга угсралтын ажлын зураг төсвийг “Некстстеп Инженеринг” ХХК гүйцэтгэж байна.

*Шувуу, хүрээлэн буй орчны чиглэлээр:* Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудал, түүний шатахууны агуулахын байгаль орчны төлөв байдлын үнэлгээнд шаардлагатай мэдээллээр “Эх Монголын байгаль” ХХК-ийг хангах, тайланг хянах ажлыг зохион байгуулсан.

“Өндөрхаан”, “Ховд”, “Дэглий цагаан”, “Чойбалсан” нисэх буудлуудын Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланг “Хан Монгол Экологи” ХХК-иар хийлгэж хүлээн авсан.

Олон нийтэд нисэх буудлын шувуу хянах үйл ажиллагаа, шувууны аюулын талаарх товч мэдээллийг Монголын үндэсний олон нийтийн телевизийн 2020 оны 05 дугаар сарын 02-ний өдрийн “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөрөөр хүргэсэн.



Шувуу үргээх тоног төхөөрөмжүүдийн ашиглалт, аюулгүй ажиллагааны зааварт нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хүрээнд “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудалд ашиглах шувуу үргээх дохион бууны заавар боловсруулсан.

Мандалговь нисэх буудлын Аэродромын ерөнхий зааврын 2.15 дугаар бүлэг буюу “Аэродром орчмын шувуу, мал, амьтдын хяналт, зохицуулалтын хөтөлбөр”-ийг хянаж сайжруулсан.

Нисэх буудлын ажилтнуудад зориулсан шувууны хяналтын үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалт, шувууны биологи, зан төрхийн мэдээлэл бүхий гарын авлага бэлтгэж “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудалд ашиглаж байна.

“Өлгий” нисэх буудлын зүгээс дараах үйл ажиллагааг хийж гүйцэтгэсэн:

- “Агаарын хөлөг шувуу, мал амьтантай мөргөлдөх аюулаас урьдчилан сэргийлэх салбар зөвлөл”-ийн шийдвэр, засаг даргын захирамжийн хэрэгжилтийг биелүүлж ард иргэддээ сэрэмжлүүлэх үүднээс орон нутгийн радио, хэвлэл мэдээллээр аймгийн төвлөрсөн хогийн цэг, хог хаягдлын хор уршиг, хог хаягдал, малын сэг зэмийг ил задгай хаяхгүй байх, нислэгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх тухай мэдээлэл хийсэн.
- Зан үйлийн “Курбан айт” баярын үеэр болон бусад үед мал нядалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хувь хүн, хуулийн этгээдүүдийг зориулалтын зөвшөөрөл бүхий газарт мал нядлуулж, зөвшөөрөлгүй ил задгай газар мал нядлахыг хориглох, малын гаралтай хог хаягдлыг битүү тагтай хогийн саванд хадгалах, хуучин хогийн цэгт нүх гаргуулан асгуулж булуулах ажлыг зохион байгуулсан.
- Аймгийн төвийн төвлөрсөн хогийн цэгийг нүүлгэн шилжүүлэх газрыг сонгох ажлыг зохион байгуулах, 2021 оны газрын төлөвлөгөөнд оруулах, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх тухай Аймгийн Засаг даргын 2020 оны 7-р сарын 21-ний өдрийн А/580 тоот захирамжийн хэрэгжилтийг хангаж хяналт тавьж, хэрэгжүүлж ажиллах талаар Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Өлгий сумын засаг дарга, Мэргэжлийн хяналтын газарт албан тоотоор хандсан.

“Гурвансайхан” нисэх буудлын элэгдэл ихтэй болон шаардлага хангахгүй байгаа Хөөрч буух хучилттай зурвас, Явгалах зам дээрх 8400 м<sup>2</sup> талбайн урсгал засварын ажлыг “Энигма Констракшн” ХХК нь ИНЕГ/ХО/ТББ/Б-12/20 дугаарт ажлын гэрээ байгуулан 2020 оны 8 дугаар сарын 30-ны өдрөөс 9 дүгээр сарын 27-ны өдөр хүртэл 29 хоногийн хугацаанд нислэг хооронд хэсэгчлэн хийж, хучилтыг 2 үеэр буюу өнгө, суурь үеийн халуун асфальтаар технологийн дагуу хийж гүйцэтгэсэн ба Иргэний нисэхийн үндэсний төвөөс томилогдсон комисс 9 дүгээр сарын 30-ны өдөр хүлээж авсан.

Тус нисэх буудлын цаг уурын автомат станц MAWS 301 маркийн тоног төхөөрөмжийг шилжүүлэх ажлын хүрээнд 700 метр газар шуудуу ухан цахилгааны кабель болон шилэн кабелийг шинээр татаж, тэмдэглэгээний шон суурилуулсан. Татлагын суурийг бетоноор цутгаж аянга зайлуулагч газардуулгыг хийсэн. Энэхүү ажлыг “Экосмарт” ХХК-ний 2020 оны 11 дүгээр сарын 08-наас 15-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэсэн.

“Доной” нисэх буудалд гэрэл суултын системийг шинээр суурилуулах ажлыг Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын 2020 оны 7 дугаар сарын 01-ний А/113 дугаар тушаалаар томилогдсон инженерийн баг батлагдсан төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгээд байна.

“Доной” нисэх буудлын аэродромын хөөрч буух хучилттай зурвасын 34 талд цаг уурын автомат станцыг шилжүүлэн суурилуулах ажлыг “АЧ СВС” ХХК хийж гүйцэтгэсэн ба Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын алба, Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны зөвлөмжийн дагуу ИКАО Doc9837 Annex-3 шаардлагуудад нийцүүлэн шилжүүлэн суурилуулсан.

“Чойбалсан” нисэх буудлын автомашины гараж, зорчигч үйлчилгээний ирэх терминал, захиргааны барилгуудын дээврийн засварын ажлыг Иргэний нисэхийн ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар “Буян нэмэх интер” ХХК хийж гүйцэтгэн 10 дугаар сард ашиглалтад хүлээлгэж өгсөн.

“Алтай” нисэх буудалд 5 автомашины гараж, ТС-1 маркийн шатахууны шинжилгээний лабораторийн ерөө, машин засварын яам, цэвэр бохирын усны холболт, ариун цэврийн ерөө, галын дохиолол, камерын хяналтын системтэй цогц барилгын ажлын явц 90%-тай байна.

*“Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын үйлчилгээний чиглэлээр:*

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 455 дугаар тогтоолоор 2020 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс “Чингис хаан” Олон улсын нисэх буудлыг “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудал гэж нэрлэх болсонтой холбогдуулан 2020 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 00:00 цагаар /UTC/ Нисэхийн мэдээллийн эмхтгэлд өөрчлөлт оруулж, “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудал болон албан ёсоор зарлагдсан.

Олон улсын нисэх буудлын нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан тус нисэх буудлын “Агаарын тээврийг хялбаршуулах хөтөлбөр”, “Аюулгүй байдлын хөтөлбөр”, “Онцгой нөхцөлийн төлөвлөгөө”, “Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцооны заавар”-ыг тус тус шинэчлэн боловсруулж, агаарын тээвэрлэгч 8 байгууллагатай нисэх буудлын ашиглалтын гэрээг шинэчлэн байгуулсан.

Тус нисэх буудлын зорчигч үйлчилгээний терминал болон ачаа шуудан үйлчилгээний цогцолборын гаалийн хяналтын бүсэд “Өөрийн үнэлгээний хуудас”-аар Буянт-Ухаа дахь Гаалийн газартай хамтран үнэлгээ хийж, “Чингис хаан” Олон улсын нисэх буудал болон Ачаа шуудан үйлчилгээний цогцолборын гаалийн хяналтын бүсийг Гаалийн ерөнхий газрын даргын 2020 оны 1 дүгээр сарын 08-ны өдрийн А/02, А/03 тоот тушаалаар 3 жилийн хугацаатай сунгуулсан.



“Аэродромын хөдөлгөөний бүсэд хөдлөх чадвараа алдсан агаарын хөлгийг шилжүүлэн байрлуулах төлөвлөгөө”-ний нийцэлд Агаарын тээвэрлэгчтэй хамтарч шинжилгээ хийхээр асуулга боловсруулж, “МИАТ” ТӨХК-д хүргүүлсэн. Хөдлөх чадвараа алдсан агаарын хөлгийг холдуулах журмын хүрээнд “Сийлэн” ХХК-тай Авто техникийн үйлчилгээний гэрээг 2020 оны 2 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан.

Монгол Улсын Онцгой комиссын шийдвэр, Шадар сайдын 33 дугаар тушаалын дагуу “Ковид-19 халдварт цар тахлын үеийн харилцан ажиллагаа, хариу арга хэмжээ” дадлага сургуулилалтын хүрээнд “Хүмүүнлэгийн тусламжийн агаарын хөлөг хүлээн авах” онцгой байдлын ширээний дасгал сургуулилтыг 2020 оны 5 дугаар сарын 06-ны өдрөөс 5 дугаар сарын 08-ны өдрүүдэд зохион байгуулсан ба уг дадлага сургуулилтад 14 байгууллагын 50 ажилтан оролцсон.

Тус нисэх буудлын Аврах, гал унтраах алба нь онцгой үүргийн хамгаалалт болон бусад дуудлагад нийт 66 удаа ажиллаж, тактик тархалтын дадлагыг 108 удаа хийсэн.

2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлаар олон улсын чиглэлийн 1659, орон нутгийн чиглэлийн 5357, нийт 7016 буулт хөөрөлт үйлдэгдэж, олон улсын чиглэлд 161622, орон нутгийн чиглэлд 266004 зорчигч, нийт 427626 зорчигч үйлчлүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад олон улсын буулт хөөрөлт 82.7%, орон нутгийн буулт хөөрөлт 24.1%, нийт буулт, хөөрөлт 57.8 % тус тус буурсан бол олон улсын зорчигч 85,7%, орон нутгийн зорчигч 32,5%, нийт зорчигч 72%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Нислэгийн саатал нийт 1512 бүртгэгдсэнээс олон улсад 610 саатал, орон нутагт 902 саатал байна. Нислэгийн саатлыг өмнөх оны үетэй харьцуулахад 56,7%-иар буурсан байна.

Ачаа шуудангийн үйлчилгээний цогцолбороор олон улсын чиглэлийн 2290 тн ачаа, 162.3 тн шуудан, орон нутгийн чиглэлийн 28.5 тн ачаа, 61.9 тн шуудан, нийт 2318.5 тн ачаа, 224.2 тн шууданг тус тус нэвтрүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад олон улсын чиглэлийн ачаа 53.8%-иар, шуудан 43.5%-иар, орон нутгийн чиглэлийн ачаа 28%-иар тус тус буурч, шуудан 42.3%-иар өссөн байна. Нийт ачаа 53.6%-иар, шуудан 32.2%-иар тус тус буурсан байна.

Хөөрч буух зурвасын гадаргуугийн барьцалт хэмжих журмын дагуу 44 удаа тусгай тоноглол бүхий SAAB 9.5 авто машинаар хөөрч буух хучилттай зурвасанд хэмжилт хийж, хэмжилтийн үр дүнг Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба болон нисэх багт дамжуулсан, агаарын хөлөг 26 удаа хөтөлж зогсоолд байрлуулсан байна.

Суултын хэсгийн ойртолтын гэрлийн 206 у/м хамгаалалтын хашааг шинээр барьсан ба хөөрч буух хучилттай зурвасын 12389,3 м2 талбай, агаарын хөлгийн зогсоолуудын 677.15 м2 талбай, перрон 558,2 м2 талбайн будан тэмдэглэгээг сэргээн будсан.

Нисэх буудлын хамгаалалтын хашааны гадна талын үерийн усны шуудууны 2424,6 у/м талбайн хавтан хоорондох заадсанд ургасан өвс ургамал болон хуучирсан чигжээсийг авч цэвэрлэсэн.

Нислэгийн төлөвлөгөөтэй уялдуулан хөөрч буух зурваст үзлэг-үргээлгийг 3211 удаа, агаарын хөлөг хөөрөх болон буух үед аэродромын ойртолтын бүс болох ВОР, ойрын чиглүүлэх станц, нислэгийн зурвас орчмыг дурагдан 2149 удаа шувууны ажиглалт хийсэн. Үзлэг-үргээлэг, ажиглалтын явцад аэродромын талбайд нийт 1192 удаа үргээлэг хийн ажилласан.

Шувуудын хавар, намрын нүүдэлтэй холбогдуулан аэродромын ойртолтын бүсээр нисэн өнгөрөх шувуудын талаарх НОТАМ мэдээг 3 удаа зарлуулсан.

#### **4.7. Газрын үйлчилгээ, шатахуун хангалтын чиглэлээр:**

2020 онд 1992 агаарын хөлөгт давхардсан тоогоор 18421 удаагийн үйлчилгээ үзүүлж, нийт 64021 мото/цаг ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал үйлчилсэн агаарын хөлгийн тоо 3.32 дахин, үйлчилгээ үзүүлсэн газрын техник, тоног төхөөрөмжийн тоо 3 дахин, үйлчилгээ үзүүлсэн цаг 2 дахин буурсан байна.

Агаарын хөлгийн газрын үйлчилгээнд 50 жолооч-операторчин, 7 онгоцны техникч, 2 инженер-оператор, нийт 59 ажилтан 42 газрын техник, тоног төхөөрөмжтэй ажиллаж байгаа бөгөөд хөдлөх бүрэлдэхүүний парк ашиглалт 25%, техникийн бэлэн байдлын коэффициент 0.98% байна.

Аэродромын цэвэрлэгээ, үйлчилгээ, засварт болон Карго терминалын ачаа, шуудан үйлчилгээний ажилд тусгай зориулалтын автомашин, механизмууд нийт 34707 км 17267 мото.цаг ажиллаж хэрэглэгчийн захиалгын дагуу технологийн зөрчил, сааталгүйгээр үйлчилгээ үзүүлээ.

Нийтийн тээврийн автомашин нь хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийт 4750 машин/өдөр ажиллаж 60,5 мянган цагийн ажил үйлчилгээ үзүүлж 710000 км явсан байна. 2019 оны мөн үеийнхтэй харьцуулбал машин/өдөр 1,7 %, ажлын цаг нь 12,5 %, нийт явсан километрийн заалт нь 11,3 %-иар тус тус буурсан үзүүлэлт гарсан байна. Үзүүлэлт буурсан нь дэлхий дахинд тархсан коронавируст халдварын цар тахлын улмаас улсын хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж хөл хорио тогтоосонтой холбоотой гэж үзэж байна.

2020 онд Ховд, Увс, Баян-Өлгий, Говь-Алтай, Өмнөговь, Хөвсгөл, Булган, Завхан аймгийн нисэх буудлуудад “Аэромонголиа”, “Хүннү эйр”, “Монголиан эйрланес”, “Тэнгэрийн улаач”, “Геосан” компаниудын захиалгаар нийт 400 тн шатахуун тээвэрлэж, 415,3 мянган т/км-ийн ажил гүйцэтгэсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тээсэн ачаа 24,6%, ачаа эргэлт 48% тус тус буурсан үзүүлэлттэй байна.





#### **4.8. Нүүлгэн шилжүүлэлт болон Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангах чиглэлээр:**

“Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэх нэгдсэн төлөвлөгөө”-г Зам тээврийн хөгжлийн Сайд 2019 оны 8 дугаар сарын 12-ны өдөр баталсан. Тус төлөвлөгөө нь нийт 4 бүлэг, 133 ажилтай бөгөөд 21 байгууллага хамтран ажиллаж байна.

“Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэх нэгдсэн төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг эрчимжүүлэх, Буянт-Ухаа дахь “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын нислэг үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эрсдэл багатай, зохион байгуулалтын өндөр түвшинд нүүлгэн шилжүүлэх, зохион байгуулагч ажлын хэсэг болон гишүүн байгууллагуудын хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулж, нэгдсэн мэдээлэлтэй болох, нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаанд тулгарах хүндрэлтэй асуудлуудыг цаг алдалгүй шийдвэрлүүлэх, нүүлгэн шилжүүлэлтийн удирдлагын төвийн үйл ажиллагааны чиг үүргийг тодорхойлох зорилгоор “Нүүлгэн шилжүүлэлтийн гишүүн байгууллагуудын хамтарсан хурал”-ыг 2020 онд нийт 7 удаа зохион байгууллаа.

Иргэний нисэхийн ерөнхий газар болон “Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” ХХК-ийн хооронд байгуулсан 105/19 дугаартай “Үйлчилгээ үзүүлэх гэрээ”-ний дагуу ИНЕГ-аас “НУБИЭ” ХХК-д хуваарилагдан ажиллаж буй ажилтныг “НУБИЭ” ХХК-д бүр шилжүүлэх тухай “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг 2020 оны 5 дугаар сарын 20-ны өдөр үзэглэж, үүний дагуу 1-3 дугаар үе шатаар шилжсэн нийт 184 ажилтнуудын “Хөдөлмөрийн гэрээ”-г ИНЕГ-ын харьяа байгууллагуудаас дуусгавар болгох ажлыг зохион байгуулсан.

Засгийн газрын 2020 оны 134 дүгээр тогтоолоор “Үйл ажиллагааг эхлүүлэх хугацаанд өөрчлөлт оруулах тухай” 227 дугаар тогтоолд өөрчлөлт оруулан УБХОУШНБ “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын үйл ажиллагааг 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн дотор эхлүүлэхээр шийдвэр гарсан. ЗТХЯ-ны 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 09/5370 дугаарт “Төлөвлөгөө шинэчлэх тухай” албан бичгээр нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэх хугацааг төлөвлөн тодорхой болгох, холбогдох бэлтгэл ажлыг хангах талаар гишүүн байгууллагуудтай хамтран нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг үүрэг болгосон. Засгийн газрын тогтоол болон ЗТХЯ-аас ирүүлсэн албан бичгийг холбогдох байгууллагуудад цахимаар танилцуулсан. Ковид-19 цар тахлын улмаас бүх нийтийн бэлэн байдал зарлаж, хатуу хөл хорио тогтоосонтой холбогдуулан уг ажил удаашралтай байна.

Улаанбаатар хотын төдийгүй эрчим хүчний нэгдсэн системийн найдвартай байдлыг нэмэгдүүлэх “Сонгино” дэд станцыг 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр ашиглалтад оруулж, хүчдэлд залгасан. Ингэснээр Хөшигийн хөндий дэх “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын цахилгаан хангамж үндсэн тэжээлээр холбогдох боломжтой болсон.

Катерингийн барилгын ажлын явц-88%, гадна зам талбайн ажил-100%, дээврийн ажил-100%, барилгын гадна цахилгаан болох хаалттай дэд өртөөг 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдөр улсын комисст хүлээлгэн өгсөн бөгөөд барилга үндсэн цахилгааны тэжээлд холбогдсон. Дотор цахилгааны ажил-68%, гадна зам талбайн ажил-100%, дотор заслын ажил-80%, холбоо, дохиоллын ажил-89,5%, тоног төхөөрөмж судалгаа, татан авалт 40%-тай байна. Цахилгаан хангалт авах, цементийн нөөц буурсан зэрэг асуудлуудаас хамаарч барилгын ажил удааширсан.

Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлын төслийн хүрээнд баригдсан агаарын хөлгийн засвар үйлчилгээний барилга нь Япон улсын ЗГ, МУ-ын Сангийн яам хооронд байгуулсан MON-P12 нэмэлт зээлийн үлдэгдэл санхүүжилтээр баригдсан. Тус барилга, байгууламжийг Барилга хот байгуулалтын сайдын 2020 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн 32 дугаар тушаалаар комисс томилогдон 2020/01-03 тоот дүгнэлтээр хүлээн авсан. Ангарын эзэмшлийг “МИАТ” ТӨХК-д шилжүүлэхээр ажиллаж байна.

#### **4.9. Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх чиглэлээр:**

“Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлыг Ерөнхий зориулалтын нисэхийн төв болгон өөрчлөн зохион байгуулах тооцоо судалгаа боловсруулж хэрэгжилтийг эхлүүлэхээр холбогдох газарт хүргүүлсэн. “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын тодорхой хэсгийг БНСУ-ын Алс дорнын их сургуульд ашиглуулан 2020 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс үйл ажиллагааг эхлүүлэхээр бэлтгэл ажлыг хангасан боловч Ковид-19 цар тахлтай холбоотой үүсээд буй нөхцөл байдлын улмаас тодорхойгүй хугацаагаар хойшлогдоод байна. Тус сургалтын төвийн үйл ажиллагаа эхэлсний дараагаар сургалтын төвийн агаарын хөлгийг түрээсээр авч ашиглах тогтолцоо бүрдүүлэхээр ажиллаж байна.

“Аймаг тус бүрийн зорчигч урсгал, хүн амын нягтаршил, авто замын сүлжил, шатахууны эрэлт хэрэгцээ зэрэг хүчин зүйлүүдийг судалж шаардлагатай хөөрч буух зурвас, шатахууны сүлжээ байгуулах газар зүйн байршлыг тогтоох судалгааны эдийн засгийн дүн шинжилгээг боловсруулсан. Тус судалгаанд бага оврын агаарын хөлгийн хөөрч буух зурвас байгуулах газарзүйн байршлыг тогтоосон бөгөөд жишиг болгон Өвөрхангай аймгийн Бат-Өлзий суманд байгуулахаар тооцож буй хөөрч, буух зурваст эдийн засгийн тооцоо судалгаа боловсруулсан. Энэхүү судалгааг Зам, тээврийн хөгжлийн яаманд 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 01/3039 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл болон тандан судалгаа боловсруулж 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 02/2831 тоот албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яамны Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хүргүүлсэн. Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 8 дугаар зүйл ГАЗРЫН ТӨЛБӨРӨӨС ЧӨЛӨӨЛӨХ гэсэн зүйлд





“Иргэний Нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон Гэрчилгээжсэн, Гэрчилгээжээгүй, Хязгаарлагдмал аэродром эзэмшиж, ашиглаж байгаа хувь хүн, хуулийн этгээдийн газрыг,” гэж тусгуулах санал боловсруулж хүргүүлсэн.

Эрдэнэт хот болон Замын-Үүд, Сайншанд, Хархорин, Дэлүүнболдог, Хужирт зэрэг сумдуудад нисэх буудал байгуулах тооцоо судалгааг боловсруулсан.

Сүхбаатар, Дорнод, Баянхонгор, Архангай аймгуудад бага оврын агаарын хөлөг хөөрч, буух зурвас байгуулах ажлын хүрээнд Баянхонгор аймгийн Богд, Баянлиг, Баянговь, Шинэжинст, Баян-Өндөр, Баянцагаан, Дорнод аймгийн Матад, Халхгол, Сүхбаатар аймгийн Их-Өлгий сумдад хээрийн түр аэродром сонгож, акт үйлдсэн.

Нисгэгч, инженер техникийн ажилтан бэлтгэх сургалтын тогтолцоо бүрдүүлэх ажлын хүрээнд Монгол улсын Зам, тээврийн хөгжлийн яам болон БНСУ-ын Алс Дорнын Их сургуультай хамтран байгуулсан санамж бичгийн дагуу Буянт-Ухаа дахь нисэх буудлын дэд бүтцийг тулгуурлан олон улсын нисэхийн сургууль барьж байгуулах тооцоо судалгааг боловсруулсан.

Бага оврын агаарын хөлөгт хөнгөлөлттэй зээл олгох холбогдох ажлын хүрээнд зорчигчдын хууль ёсны хариуцлагын даатгал болон бусад ерөнхий зориулалтын нисэхийн даатгалын төрөл зүйлийн талаарх судалгааг боловсруулсан.

“Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ, заагийг тогтоох, ашиглах журам”-д өөрчлөлт оруулах тухай засгийн газрын тогтоолын төсөлд холбогдох саналуудыг судалгаа, шинжилгээний үндсэн дээр Зам, тээврийн хөгжлийн яамны холбогдох ажилтанд хүргүүлсэн.

Хэнтий аймгийн Галшар суманд хээрийн түр аэродром сонгох журам болон аэродромд тавигдах шаардлагад нийцүүлэн Cessna 208 агаарын хөлөг хөөрч буух хээрийн түр зурвас байгуулах газрыг сонгосон.

Иргэний нисэхийн ерөнхий газар, Бүгд Найрамдах Чех Улсын Тээврийн яам хоорондын нисэхийн салбарт хамтран ажиллах санамж бичгийн төслийг эцсийн байдлаар боловсруулан Зам, тээврийн хөгжлийн яам, Гадаад харилцааны яамнаас зөвшөөрөл авахаар ажиллаж байна.

Агаарын зайн мэдээллийг дижитал хэлбэрт шилжүүлэх, агаарын зайн мэдээллийг хэрэглэгчдэд хүргэх ажлын хүрээнд агаарын зайн мэдээллийн систем (ga.mcaa.gov.mn)-ийг ажиллагаанд оруулаад байна.

АНУ-ын элчин сайд болон FAA байгууллагын зүүн ази хариуцсан төлөөлөгч, бусад албаны хүмүүстэй 2020 оны 12 дугаар сарын 20-ны өдөр цахим уулзалт зохион байгуулж Ерөнхий зориулалтын нисэхийн чиглэлээр хамтарч ажиллах сургалт зохион байгуулахаар тохиролцсон.

#### **Тав. Төрийн захиргааны удирдлагын чиглэлээр:**

*Хүний нөөцийн удирдлагатай холбоотой нийтлэг үйлчилгээ, үйл ажиллагааг зохицуулах талаар:*

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/171 дүгээр тушаалаар батлагдсан зохион байгуулалтын бүтцийн дагуу агентлаг 106, үйлдвэрлэлийн салбар, нэгжүүд 2431 орон тоотой үйл ажиллагаагаа явуулж байна.

ИНЕГ-ын даргын 2020 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/416 дугаар тушаалаар “Хөдөлмөрийн дотоод журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулж, 2020 оны 10 дугаар сарын 05-ны өдрөөс мөрдөн ажиллаж байна. “Хөдөлмөрийн дотоод журам”-д орсон нэмэлт, өөрчлөлтийг тусган эх бэлтгэн хэвлүүлж, ХДЖ-ын 11 дэх хэвлэлийг ажилтнуудад тараасан.

Иргэний нисэхийн салбарт 2019-2021 онд хэрэгжих Хамтын хэлэлцээр болон ИНЕГ, түүний харьяа байгууллагуудад 2020-2021 онд хэрэгжих Хамтын гэрээний хэрэгжилтийг гаргаж, 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 02/2851 тоот албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яамны Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хүргүүлсэн. Хамтын хэлэлцээрийн биелэлт 94,7 хувь, Хамтын гэрээний хэрэгжилт 99 хувьтай байна.

Ажилтнуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэлийг үнэлэх журмыг шинэчлэн боловсруулж ИНЕГ-ын даргын 2020 оны А/461 дүгээр тушаалаар батлуулсан.

Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт-08-д оруулах саналаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/199 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт-08-д нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэх аргачлал”-ын дагуу гаргаж 2020 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 01/2719 тоот албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн.

ИНЕГ-ын даргын 2020 оны А/251 дүгээр тушаалаар агентлагийн 89 ажилтны ээлжийн амралтын хуваарийг батлуулж, 86 ажилтанд ээлжийн амралтын хуудас олгосон.

*Хурал, зөвлөгөөний талаар:*

Тайлант хугацаанд Даргын зөвлөл 2020 онд 15 удаа хуралдаж, 27 асуудал хэлэлцэж 75 үүрэг даалгавар өгсөн. Хурлаас гарсан шийдвэрийг албажуулан холбогдох албан тушаалтнуудад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. Үүрэг даалгаврын хэрэгжилт 80 хувь.

ИНЕГ-ын даргын шуурхай зөвлөгөөнийг тухай бүр зохион байгуулж, хурлын тэмдэглэл хөтлөн, өгсөн үүрэг даалгаврыг холбогдох газруудад хүргүүлэн биелэлтэд хяналт тавин ажиллаж байна. 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар даргын шуурхай хуралдаан нийт 22 удаа зохион байгуулагдаж, 384 үүрэг даалгавар өгөгдсөн. Үүрэг даалгаврын хэрэгжилт 90 хувьтай байна.



Зам, тээврийн хөгжлийн Сайдын шуурхайгаас өгсөн үүрэг даалгаврыг холбогдох албан тушаалтнуудад цаг хугацаанд нь хүргэж, хэрэгжилтийн талаарх мэдээллийг долоо хоног бүрийн Пүрэв гарагт нэгтгэн гаргаж, Зам, тээврийн хөгжлийн яаманд тогтмол хүргүүлж байна. Нийт 43 үүрэг даалгавар өгснөөс 100%-ийн хэрэгжилттэй 40, 70%-ийн хэрэгжилттэй 3 ажил байна. Үүрэг даалгаврын хэрэгжилт 97,9 хувь.

*Хүний нөөцийн бүртгэл, судалгааны талаар:*

Хүний нөөцийн холбогдолтой ажилд авах, чөлөөлөх, шилжүүлэн ажиллуулах, чөлөө олгох, тэтгэмж тусламж олгох, сахилгын шийтгэл ногдуулах, нэмэгдэл урамшуулал олгох зэрэг тушаал шийдвэрийг тухай бүрт нь төлөвлөж, батлуулан, хүний нөөцийн туслах бүртгэлд тусган ажиллаж байна. 2020 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар үндсэн орон тоонд 20, түр орон тоонд 14 хүнийг ажилд томилж, 65 ажилтныг шилжүүлэн ажиллуулсан байна.

*Албан хэрэг хөтлөлт, архивын ажлын талаар:*

Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлуулан, хэрэгжилтийг хангасан ажилласан. тус газарт мөн оны 3 дугаар улиралд ирэхтэй холбогдуулан төлөвлөгөө гарган ажилласан. Төлөвлөгөөний хэрэгжилт 86,3 хувь.

2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар нийт 4403 албан бичиг ирснээс 1054 нь хариутай бичиг байна. Үүнээс 959 албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэж, 59 албан бичгийн шийдвэрлэх хугацаа болоогүй, 36 албан бичиг шийдвэрлэх шатанд байна. Албан бичгийн шийдвэрлэлт 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 91 хувьтай байна.

2020.12.10-ны өдрийн байдлаар үйл ажиллагааны чиглэлээр А тушаал нийт 466, боловсон хүчний чиглэлээр Б тушаал 257 гарсан байна. Үйл ажиллагааны чиглэлийн 466 тушаалын 655 заалтыг хяналтанд авч хэрэгжилтийг ханган ажилласан бөгөөд жилийн эцсийн байдлаар хэрэгжилт нь 88,7%-тай, боловсон хүчний чиглэлээр гарсан 257 тушаалын хэрэгжилт 100%-тай байна.

2019 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар нийт 339 өргөдөл, гомдол ирүүлснээс 333 өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариу өгсөн. Шийдвэрлэх хугацаа болоогүй хяналтанд байгаа 6 өргөдөл гомдол байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлт 98,2%-тай байна. Иргэдээс ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх тайлан мэдээг улирал бүр байгууллагын цахим хуудсанд байршуулж олон нийтийг мэдээллээр хангаж, ЗТХЯ-нд тогтмол хүргүүлж байна.

2018-2019 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу ИНЕГ болон харьяа байгууллагуудаас баримт бичгийг хүлээн авч, бүртгэл үйлдсэн. "Байгууллагын архивын ажлын үндсэн заавар", "Баримт бичиг хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалт"-ыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан. 2018-2019 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу ИНЕГ болон харьяа байгууллагуудаас нийт 3970 хадгаламжийн нэгж баримт бичгийг архивт хүлээн авч, заавар, журмын дагуу эмхлэн цэгцэлж бүртгэл үйлдсэн. Үүнд:

- Байнга хадгалах баримт 747 хн
- 70 жил хадгалах баримт 212 хн
- Түр хадгалах баримт 3011 хн

Архивт хүлээн авсан баримтын бүртгэл, архивын лавлагаа олгосон тухай бүртгэл, байгууллага албан тушаалтанд түр олгосон баримтын бүртгэл, хадгаламжийн санд цэвэрлэгээ үйлчилгээ болон норматив дэглэмийг хангаж ажилласан тухай бүртгэлүүдийг тухай бүр хөтлөн явуулж байна. Архивт хадгалагдаж буй баримтаас нийт 182 хадгаламжийн нэгж /3222 хуудас/ лавлагаа гаргаж, ИНЕГ болон харьяа алба, хэлтсийн ажилтнуудад 501 хадгаламжийн нэгж баримтыг түр ашиглуулахаар олгосон байна. хадгалагдаж байгаа баримтаас нийт 203 хадгаламжийн нэгж /3066 хуудас/ лавлагаа гаргасан.

Байгууллагын баримт бичиг нягтлан шалгах комиссын 2020 оны 01 дугаар сарын 13-ны өдрийн 01 дүгээр хурлаар 2020 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг хэлэлцүүлж, батлуулсан.

*Шагнал урамшуулал, нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн талаар:*

Шинэ төрлийн корона вирусийн тархалтын улмаас улсын хэмжээнд 2020 онд нийтийг хамарсан урлаг, спорт, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй тул шагнал, урамшууллын асуудлууд мөн хойшлогдсон. Нисэх хүчин үүсч хөгжсөний 95 жилийн ойн баяр, Ардын хувьсгалын 99 жилийн ойн баярыг тохиолдуулан Төрийн дээд одон, медалиар шагнуулах 111 ажилтны материалыг ЗТХЯ-нд, Иргэний нисэхийн салбарын 14 ахмад настны материалыг ХУД-ийн ЗДТГ-т тус тус хүргүүлсэн.

Олон улсын нислэгийн удирдагчдын өдөр, Хүний нөөцийн ажилтны өдрийг тохиолдуулан, мөн 2020 оны ажлын үр дүнг харгалзан ИНЕГ-ын "Жуух бичиг", "Баярын бичиг"-ээр 159 ажилтныг шагнаж урамшуулсан байна.

Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг 2020 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, ИНЕГ-ын даргаар батлуулсан. 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар ажилтнуудын нийгмийн баталгааг хангах, тэтгэмж, тусламж, олгох чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- Өндөр насны тэтгэвэрт гарсан 37 ажилтанд 2,753.4 сая төгрөг Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу тэтгэмж олгосон. Үүнд: салбарт ажилласан жилээс нь хамруулж 21 ажилтанд 36 сарын 2,146.7



- сая төгрөгийн тэтгэмж, 2 ажилтанд 25 сарын 85.1 сая төгрөгийн тэтгэмж, 11 ажилтанд 18 сарын 464.3 сая төгрөгийн тэтгэмж, 2 ажилтанд 12 сарын 46.5 сая төгрөгийн тэтгэмж, 2 ажилтанд 2 - 4 сарын 7.7 сая төгрөгийн тэтгэмжийг тус тус олгосон.
- Өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа түр алдсан 13 ажилтан үндсэн цалингийн 70 хувьтай тэнцэх 21.7 сая төгрөг тэтгэмж, групп тогтоолгож ажлаас чөлөөлөгдсөн 10 ажилтанд 639.6 сая төгрөгийн тэтгэмж олгосон.
  - Хүнд өвчний улмаас дотоодод өндөр төлбөртэй эмчилгээ хийлгэсэн 3 ажилтны эмчилгээний зардалд 8.8 сая төгрөг олгов.
  - Ар гэрийн гачигдал гарсан 135 ажилтанд тус бүр 300 000 төгрөгийн буцалтгүй тусламж, нас барсан 4 ажилтны гэр бүлд 131.5 сая төгрөгийн тэтгэмж, нас барсан 13 өндөр настны гэр бүлд нь тус бүр 1 000 000 төгрөгийн буцалтгүй тусламж олгосон.
  - ИНЕГ, түүний харьяа салбарын 2 ажилтанд мэргэжил, боловсролоо дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор 1 жилийн сургалтын төлбөрийн 70 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэмж 5.3 сая төгрөгийг байгууллагаас гаргасан.
  - Хүүхэд төрүүлсэн 34 эмэгтэй ажилтанд тус бүр 2 000 000 төгрөгийн тэтгэмж 58.0 сая төгрөг олгосон.
  - Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 1014 эмэгтэй ажилтан тус бүрт 50 000 төгрөгийн гарын бэлэг гардуулсан
  - Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан ажилтны 16 нас хүрээгүй 2640 хүүхэд тус бүрт 25 000 төгрөгийн гарын бэлэг тус тус олгосон.
  - Цагаан сарын баярыг тохиолдуулан 607 өндөр настанд 50 000 төгрөг, 80 настай 15 өндөр настанд 100 000 төгрөг, 81-89 настай 44 өндөр настанд 150 000 төгрөг, 90 настай 5 өндөр настанд 250 000 төгрөгийн гарын бэлэг гардуулсан.
  - Нисэх хүчин үүсч хөгжсөний 95 жилийн ойг тохиолдуулан 663 өндөр настанд тус бүр 50 000 төгрөг, ИНЕГ-ын гавьяат болон түүнээс дээш цолтой 10 өндөр настанд тус бүр 500 000 төгрөгийн гарын бэлэг гардуулсан.
  - Ахмадын баярыг тохиолдуулан 680 өндөр настанд тус бүр 50 000 төгрөг, 2019 онд улсын тэргүүний ахмадын хороо болсон тул 8 өндөр настанд тус бүр 112 500 төгрөгийн гарын бэлэг гардуулсан.
  - Шинээр гэр бүл болсон 4 ажилтанд тус бүрт 250 000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.
  - ИН-ийн хүндэт ажилтан тэмдэгээр шагнагдсан 9 ажилтан /өндөр настан/, үүнээс олон улсад 7 зорчиж 11.4 сая төгрөг, орон нутагт 2 зорчиж 767.6 мян төгрөг буюу нийт 12.2 сая төгрөгний нислэгийн тийзийн хөнгөлөлтийг олгосон.
  - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 7 ажилтанд хүүхдийн эмчилгээнд зориулж ажилтны гаргасан хүсэлт, эмнэлгийн магадлагааг үндэслэн 500 000 төгрөгийн тэтгэмжийг олгосон.
  - Ажлаас чөлөөлөгдсөн буюу халагдсан 2 ажилтанд 59.3 сая төгрөгний тэтгэмж олгосон.
  - Хичээлийн шинэ жилийг тохиолдуулан ажилтнуудын 482 хүүхдэд хүүхэд тус бүрт 50 000 төгрөг олгож 24.1 сая төгрөг олгосон.

*Сэргээн засах амралт:*

Материаллаг бааз, туршлагадаа тулгуурлан амралт, чөлөөт цагаа эрүүл агаарт, тав тухтай орчинд өнгөрүүлж, алжаал ядаргаагаа тайлах зорилго бүхий иргэд болон байгууллага хамт олны тэмдэглэлт ойн арга хэмжээний хүлээн авалт, олон улсын чанартай хурал зөвлөгөөн, сургалт, урлагийн арга хэмжээ, спортын тэмцээн уралдаан зохион байгуулж байна.

2019 оны жилийн эцсийн байдлаар тус амралтын газраар нийт 16,980 хүн үйлчлүүлснээс хувь хүн 10,820 захиалгат үйлчилгээгээр 92 байгууллагын 6160 хүн үйлчлүүлсэн. Үүнээс салбарын ажилчин албан хаагчид давхардсан тоогоор 2416 хүн үйлчлүүлсэн байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас зарласан **“Ахмад настанд амралт сувиллын үйлчилгээ үзүүлэх”** тендерт шалгарч 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдөр хамтран ажиллах гэрээ байгуулсан. 2019 оны 07 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн эхний ээлжийн ахмадуудыг хүлээн авсан. 2019 онд Улаанбаатар хот болон хөдөө орон нутгаас ирсэн 165 ахмад настанд амралт сувиллын үйлчилгээг үзүүлээд байна.

*Байгууллагын дотоод үйл ажиллагаа, олон нийттэй харилцах, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах талаар:*

Нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын мэдээллийн “WINGS” сэтгүүлийн 3 дугаарыг НААХЗА-тай хамтран гаргав.

“Мэдээллийн цаг-2019”-ийн төлөвлөгөө батлуулан тайлант хугацаанд нийт 21 мэдээллийн цагийг зохион байгууллаа. Тухайлбал, хувь хүний хөгжил, ажилтны ур чадварыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд “Цахим англи хэл”, “Эрдэнэс-Тавантолгой ХК-аас 1072ш хувьцаа”, “Хүүхдийг хүмүүжүүлэх эерэг арга”, Хэрхэн зөв, зохистой хооллох вэ, ажлын байранд хөдөлгөөний дутагдлаас сэргийлье”, “Хүүхдийнхээ мэргэжил



сонголтыг хэрхэн зөв хийх вэ”, “Үнэт цаасны арилжаанд хэрхэн оролцох вэ”, “Монгол болон Япон улсын нийгэм, албан байгууллага, иргэдийн хандлага, жендерийн эрх, харилцааны ялгаа”, Төрийн байгууллагын ажилтнуудад зориулсан хүүхдийн хадгаламжийн үйлчилгээ болон, орон сууцны 8 хувийн зээлийн уян хатан нөхцөл, “Жендер, ажлын байран дээрх эрх тэгш харилцаа”, “Ажлын байран дахь дарамт, хүчирхийлэл, хүний эрх гэж юуг хэлэх вэ” зэрэг сэдвээр ажилтнуудад сургалт, мэдээлэл хийлээ.

Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах ажлыг эрчимжүүлэх үүднээс захиалгын гэрээтэй хамтарч ажилладаг өдөр тутмын Өдрийн сонин, Үндэсний шуудан, Монголын мэдээ, Монголын үнэн, Зууны мэдээ сонинуудад алба салбаруудад хийгдсэн ажлын талаарх тогтмол мэдээлэл гаргах хуваарийг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж, 20 гаруй мэдээллийг нийтлүүлээ.

2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар салбарын үйл ажиллагааг олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр сурталчлах ажлын хүрээнд давхардсан тоогоор 18 сайт, өдөр тутмын 5 сонин, 13 телевизээр 89 мэдээ, мэдээлэл, ярилцлагыг тухай бүрт нь нийтэлж, нэвтрүүллээ.

- БНСУ, БНТУ-тай хийсэн агаарын харилцаанд нэмэлт, өөрчлөлт оруулсан тухай мэдээлэл, ярилцлага,
- Хөшигийн хөндийн шинэ нисэх буудлын концессийн гэрээг үзэглэх, хэсэгчилсэн нээлтийн сурвалжлага, мэдээлэл, ярилцлага
- Нисэхийн эрэн хайх, авран туслах дотоодын байгууллагуудыг хамруулсан анхны Дотоодын SAREX зохион байгуулсан талаар мэдээ, сурвалжлага
- Непал улсад зохион байгуулагдсан Ази, номхон далайн орнуудын иргэний нисэхийн захирлуудын хурлын талаарх цуврал мэдээлэл,
- Засгийн газраас зохион байгуулсан Нээлттэй хаалганы өдөрлөгөөс хийсэн сурвалжлага, мэдээлэл
- Улаанбаатар хотын ОУШНБ-ын ажлын явц, ашиглалтын талаар, Бойнг МАХ 8 онгоц болон манай улсад нисэхийн аюулгүй ажиллагааг хэрхэн хангаж ажилладаг талаар ИНЕГ-ын дарга, Дэд дарга нараар телевизэд дэлгэрэнгүй ярилцлага өгүүлсэн.
- МИАТ, Хүннү эйр, Аэромонголиа авиа компаниудын парк шинэчлэл, Бойнг737-800, Embreag агаарын хөлгийг оруулж ирсэн тухай,
- Нисэх хүчин үүсч хөгжсөний 94 жилийн ой, ЗТХ-ийн сайд нисэхэд ажилласан, ИНЕГ иж бүрэн спорт цогцолбортой болох гэх мэт мэдээ мэдээллүүдийг олон нийтэд хүргэж ажиллалаа.

2019 оны 12 дугаар сарын 12-ны байдлаар ИНЕГ-ын цахим хуудсанд 161 мэдээ, мэдээллийг, мөн 7 хоног тутамд нислэгийн мэдээ, цаг агаарын мэдээг шинэчлэн байршууллаа.

Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх зорилгоор 2019 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс МИАТ ТӨХК-тай, 2019 оны 2 дугаар сарын 26-ны өдрөөс “ЕСКК” ХХК-тай “Спорт заал ашиглуулах, түрээслүүлэх гэрээ”-г тус тус байгуулан, хуваарийн дагуу ИНЕГ, түүний салбар нэгжийн ажилтнуудыг спорт зааланд тоглуулж байна.

ЗТХЯ-наас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг спортын 5 төрөлт тэмцээнд амжилттай оролцож, 3 дугаар байр эзэллээ.

Монгол Улсад нисэх хүчин үүсч хөгжсөний 94 жилийн ой, Иргэний агаарын тээвэрчдийн өдөрт зориулсан салбарын аварга шалгаруулах спортын 6 төрөлт тэмцээн зохион байгуулж, ИНЕГ түүний харьяа алба, салбарууд, агаарын тээврийн компаниудын нийт 18 байгууллагын 1000 гаруй тамирчин өрсөлдөө. Тэмцээнүүдийн нийлбэр дүнгээр “Чингис хаан” ОУНБ-ын баг тамирчид тэргүүн байр эзэлж, “Шилжин явах цом”-ын эзэн боллоо.

Ажилтнуудын бие бялдрыг хөгжүүлэх, эрүүл мэндийг хамгаалах, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор “Хаврын баяр-2019” нэгдсэн арга хэмжээг уулын алхалт, олс таталт, хөл бөмбөг, уулын оргил булаалдах зэрэг спортын хөтөлбөртэйгээр Сэргээн засах амралтад зохион байгуулав.

“Улаанбаатар марафон-2019” Олон улсын гүйлтийн уралдаанд ИНЕГ, түүний харьяа салбар, нэгжийн нийт 22 гүйгч оролцож батламжаа гардсан.

Бие бялдын хөгжилт чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг ИНЕГ, түүний харьяа салбар байгууллагуудын хэмжээнд 2019.04.01-2019.4.31-ний өдрүүдэд зохион байгуулж 1056 ажилтан хамрагдаж, улсын хэмжээний бүртгэлийн програмд мэдээллийг оруулсан.

Халхын голын байлдааны түүхэн ялалтын 80 жилийн ойг тохиолдуулан ИНЕГ-аас томилогдсон ажлын хэсэг болон Иргэний нисэхийн үйлдвэрчний эвлэлийн хороо, Нисэхийн залуучуудын холбооны төлөөлөл 60 гаруй хүнийг хамруулсан "Иргэний нисэхийнхэн их ялалтын жимээр" тойрон аяллыг зохион байгууллаа.

#### *Сургалтын талаар:*

ИНЕГ, түүний харьяа байгууллага, харилцагч байгууллагуудаас ирүүлсэн саналыг нэгтгэн, 2019 оны сургалтын төлөвлөгөөг батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллалаа. Үүнд:

– “Нисэхийн сургалтын төвд 2019 онд зохион байгуулагдах дотоод сургалтын төлөвлөгөө”-г 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдөр батлуулсан бөгөөд нийт 46 төрлийн 52 сургалтыг 151 ээлжээр зохион байгуулж, давхардсан тоогоор 1747 ажилтан амжилттай хамрагдаж, гэрчилгээжлээ.

– Захиалгат 8 төрлийн 17 сургалтад 21 ээлжээр 238 ажилтан хамрагдсан. БНСУ-ын Хансёо Их сургуулийн агаарын тээвэр, нисэх буудлын чиглэлээр суралцаж буй оюутнууд танилцах сургалт дадлагад



хамрагдсанаараа онцлог байлаа.

– “Гадны сургалтын байгууллагуудад 2019 онд зохион байгуулагдах дотоод сургалтын төлөвлөгөө”-г 2019.02.21-ний өдөр батлуулан, 99 сургалтаас 91 сургалт зохион байгуулагдаж, давхардсан тоогоор 706 ажилтан амжилттай хамрагдлаа.

ICAO-ийн TRAINAIR PLUS хөтөлбөрийн хүрээнд 2019 онд зохион байгуулагдах сургалтын төсвийг батлуулж, “Aeronautical Information Management Specialist” 021/122/AIS AIM SPC стандартчилагдсан сургалтын багц хөтөлбөрийн олон улсын сургалтыг 2019 оны 11 дүгээр сарын 15-25-ны хооронд зохион байгуулж, ИНЕГ-ын харьяа НМҮА-ны 3 мэргэжилтэн, Бүгд Найрамдах Тунис Улсын иргэний нисэх, нисэх буудлын удирдах газрын 2 суралцагч амжилттай хамрагдаж ICAO-аар гэрчилгээжив. Сургалтын зар сурталчилгааг ICAO-ийн болон ИНЕГ-ын цахим хуудас, цахим шуудан, сошиал сүлжээ, НМҮА-ны гадаад харилцаа холбоог ашиглан түгээн ажилласан бөгөөд үйл ажиллагааны түүхэн баримтыг зургаар үлдээх зорилгоор ОУ-ын болон урт хугацааны сургалтуудад төгсөгчдийн монтаж хийж төгсөгчдөд дурсгал болгон хадгалуулах ажлыг хийж эхлээд байна.

ИНЕГ-ын даргын 2019 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн А/322 дугаар тушаалаар сургалтын асуудал хариуцсан байнгын зөвлөлийг 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан бөгөөд 5 удаа хуралдаж, шинээр 27 оюутан суралцуулах, 7 оюутны сургалтын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, 30 барьцаа чөлөөлүүлэх асуудлыг тус тус шийдвэрлүүлсэн.

Байгууллагын зардлаар 2019 оны 12 дугаар сарын байдлаар 13 гадаад улс оронд 28 мэргэжлээр 72 оюутан суралцаж байна. Байгууллагын зардлаар суралцаж төгссөн 20 хүнээс энэ жил 4 хүнийг ажлын байраар хангасан. /НБУГ-2, ЗУГ-1, Чингис хаан ОУНБ-д 1/

**Зургаа. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хууль зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх чиглэлээр:**

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн биелэлтийг Авлигатай тэмцэх газарт тогтмол хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 387 дугаар тушаалаар ИНЕГ-ын зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт орсонтой холбогдуулан ХАСХОМ гаргах албан тушаалтны жагсаалтыг шинэчлэн, ИНЕГ-ын даргын 2020 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн А/169 дүгээр тушаалаар баталсан.

Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, авлигаас урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээг танилцуулах зорилгоор 2020 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөний дагуу сургалтыг 2020 оны 4 дүгээр сараас эхлүүлэхээр бэлтгэлийг хангаж авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах сургалтын танилцуулга, презентаци бэлтгэсэн. Цар тахлын улмаас олон нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулахыг хориглосон тул авлигын эсрэг хууль тогтоомжийг цахимаар нийт ажилтнуудад цувралаар танилцуулсан. Авлигын эсрэг авч хэрэгжүүлэх төрийн байгууллагын нийтлэг үүрэг, ИНЕГ-ын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, ашиг сонирхлын зөрчил, түүнийг хэрхэн мэдээлэх талаар мэдээлэл бэлтгэж, цахимаар нийт ажилтнуудад хүргүүлсэн. Мөн АТГ-т 2020 онд зохион байгуулах сургалтад хамруулах 60 ажилтны нэрсийг хүргүүлсэн. АТГ-ын соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран “Авлигын гэмт хэрэг, авлигын хор уршиг” сэдвээр 2020 оны 10 дугаар сарын 16-ны өдөр сургалт зохион байгуулж, 56 ажилтан хамрагдсан.

Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний харьяа байгууллагуудын Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтнуудын жагсаалт гарган АТГ-т хүргүүлсэн. ХАСХОМ гаргахтай холбогдуулан мэдүүлэг гаргах ажилтнуудад 2 удаа сургалт зохион байгуулсан. 2020 онд 152 ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд гаргуулж авч, тайлан мэдээг 2020 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 01/544 тоот албан бичгээр АТГ-т хүргүүлсэн. ХАСХОМ-ийг хугацаандаа гаргаагүй хоцроосон албан тушаалтан байхгүй. Мэдүүлэг гаргагчдын цаасаар болон цахим хэлбэрээр өгсөн мэдүүлэг бүрэн гүйцэд бөглөгдсөн, хугацаандаа өгөхөд хяналт тавьж ажилласан. 2020 онд ХАСХОМ гаргах албан тушаалд шинээр томилогдсон 61 ажилтнаас ХАСХОМ-ийг гаргуулж авсан.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.2 дахь заалт, 8 дугаар зүйл болон Монгол Улсын Их хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын 3.5.3-т заасны дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх мэдэгдлийг 486 албан тушаалтнаас авсан. Захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт шалгалт хийхэд ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй нөхцөлд АСМ-ийг гаргуулж байна. 2020 онд 9 албан тушаалтан захиргааны шийдвэр гаргахдаа ашиг сонирхлын зөрчилтэй гэсэн мэдэгдлийг гаргасан.

Албан тушаалд томилогдсон албан хаагчдын хөрөнгө, орлогын мэдүүлгийг 30 хоногийн дотор гаргуулж хэвшсэн. 2020 онд 67 ХАСУМ-ыг АТГ-аар хянуулж, 61 нэр дэвшигчийг томилоод байна. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСУМ/-ийг хянасан дүгнэлтийг байгууллагын цахим хуудсанд байршуулж нийтэд ил тод болгосон. “Мэдүүлгийн бүрдүүлэлтийн программ” дахь “ЭБАТ” цэсний ХАС-ын урьдчилсан мэдүүлгийн бүртгэлд тухай бүр мэдээллийг оруулж байна. ХАСХОМ-ийг цахимаар гаргуулан авч, баталгаажуулан, Авлигатай тэмцэх газраас баталсан бүртгэлийн маягтын дагуу бүртгэж байна.

Иргэдэд үзүүлэх үйлчилгээнд хүнд суртал гаргаж, иргэдийг чирэгдүүлсэн тохиолдлыг илрүүлж, буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох, иргэдээс авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой мэдээлэл авах зорилгоор буланг цахим хуудаснаа нээн ажиллуулж байна. Одоогоор авлигатай холбоотой ямар нэгэн мэдээлэл ирээгүй байна.





Иргэний агаарын тээвэр дэх Цагдаагийн хэлтэстэй хамтарч 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр сургалт зохион байгуулж, нийт 40 ажилтан хамрагдсан.

ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх газартай хамтран “Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөл” сэдвээр 36 хуудас материал бэлтгэн 2020 оны 07 дугаар сарын 30-ны өдөр, “Согтууруулах ундааны хор хөнөөл” сэдвээр 21 хуудас материал бэлтгэн 2020 оны 08 дугаар сарын 14-ны өдөр нийт ажилтнуудад цахимаар мэдээлэл хүргэсэн. 2020 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр ИНЕГ-ын 50 ажилтан Хар тамхитай тэмцэх газрын Сургалт, мэдээллийн тэнхимтэй танилцаж “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хор уршиг, үр дагавар түүнээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтад хамрагдсан. “Согтууруулах, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хор уршиг, үр дагаврын талаарх мэдээллээр салбарын ажилчдыг хангах, ухуулах таниулах ажлыг холбогдох төрийн байгууллагатай хамтран зохион байгуулна” гэсэн албан даалгаврын хүрээнд “Анхааруулга” сэдвийн дор 3 төрлийн зурагт хуудсыг бэлтгэн хэвлүүлж, ажлын байр, заал танхимуудад байршуулсан.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2020 оны 10 дугаар сарын 16-ны өдөр “Авлигын эсрэг гэмт хэргийн тухай” сургалтыг зохион байгуулж, 50 ажилтан хамрагдсан. Хан-Уул дүүргийн Цагдаагийн 2-р хэлтэстэй цахим орчинд үйлдэгдэж байгаа залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “ЯТГАХ ТУСАМ НЯГТАЛ-2” нөлөөллийн арга хэмжээний хүрээнд “Цахим орчин дахь залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөмж”, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж байгаатай холбогдуулан хуулийн талаар “Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн танилцуулга” мэдээлэл бэлтгэн ажилтнуудад цахимаар хүргэсэн.

### ***Долоо. Санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр***

2020 оны улсын төсөвт төвлөрүүлэх навигацгийн орлогыг сарын хуваарийн дагуу хугацаанд нь төвлөрүүлсэн. 2020 оны байдлаар 75.0 тэрбум төгрөг төсөвлөгдөж 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 71.5 тэрбум төгрөгийг сарын хуваарийн дагуу хугацаанд нь бүрэн төвлөрүүлсэн. 12 дугаар сарын орлогын хуваарийн дагуу 3.5 тэрбум төгрөгийг хугацаанд нь төвлөрүүлж тайлагнана.

#### ***2020 оны үйл ажиллагааны төсөв боловсруулан нэгтгэж, батлуулах***

– Иргэний нисэхийн ерөнхий газар, харьяа алба, салбарын тухайн жилийн төсвийн хязгаар, төсвийн төсөл, дараа жилийн төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийг орлого, зардлын 45 үзүүлэлт бүрээр нэгтгэн хянаж, Зам, тээврийн хөгжлийн яам, Сангийн яаманд хугацаанд нь хүргүүлсэн.

– Зам тээврийн хөгжлийн сайд, Сангийн сайдын 2020 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 167/161 дугаар “Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Үндэсний төвийн 2020 оны орлого, зарлагын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хамтарсан тушаал батлуулсан.

– 2021 оны төсвийг 2020 оны 7 дугаар сарын 25-ны өдөр ЗТХЯ-нд хүргүүлсэн бөгөөд цар тахлын улмаар 2021 оны орлого буурах, улсын төсөвт төвлөрүүлэх орлого тооцооллоос өндөр батлагдсан тул зардлыг дахин харах шаардлагатай болж харьяа алба, салбаруудын 2021 оны төсвийг дахин санал авч 2020 оны хүлээгдэж буй гүйцэтгэлтэй уялдуулан хянаж нэгтгэсэн.

– ХНАА, ГТҮШХА-ны бүтэц зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан тус албадын цалингийн сүлжээг шинэчлэн боловсруулж батлуулсан.

#### ***Санхүүгийн бүртгэл, тайлан гаргах***

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2019 оны жилийн эцэс, 2020 оны хагас жилийн санхүүгийн тайланг хугацаанд нь гарган Зам, тээврийн хөгжлийн яам, Сангийн яам, Татварын ерөнхий газар, Үндэсний Аудитын газарт хүргүүлж баталгаажуулан байгууллагын шилэн дансын цахим хуудсанд байршуулан нийтэд ил тодоор тайлагнан ажилласан.

2020 онд Иргэний нисэхийн ерөнхий газар нийгмийн даатгалын шимтгэлд 15.5 тэрбум, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварт 6.5 тэрбум төгрөг, Нэмэгдсэн өртгийн албан татварт 190.5 сая төгрөг, Хувь хүний орлогын албан татварт 5.9 тэрбум төгрөг, Үл хөдлөх хөрөнгийн болон газрын албан татварт 4.3 тэрбум төгрөг, Ногдол ашиг 4.9 тэрбум төгрөг тус тус төвлөрүүлж улсын болон орон нутгийн төсөвт нийт 37.2 тэрбум төгрөгийг төвлөрүүлээд байна.

#### ***Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт:***

– Ажилтнуудын эзэмшиж байгаа хөрөнгийн бүртгэлийн картыг нэр бүрчлэн хөтөлж баталгаажуулсан. 2020 оны хагас жилийн тооллогоор 1 их наяд 912.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 18.4 тэрбум төгрөгийн бараа материал тоологдож, ашиглалтын хугацаа дууссан 1.1 тэрбум төгрөгийн 357 нэрийн үндсэн хөрөнгийг актлах саналыг Өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцүүлж Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэн шийдвэр гаргуулж актласан.

#### ***Агаарын тээвэрлэгчдийн авлага барагдуулах талаар:***

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2020 оны төсвийн орлогын төлөвлөгөөний дагуу салбар, нэгжийн гадаад, дотоодын агаарын тээвэрлэгчид, бусад аж ахуйн нэгж байгууллагад үзүүлсэн үйлчилгээний төлбөрийг тухай бүрт нь тооцоолон цахим болон цаасан хэлбэрээр 3271 нэхэмжлэхийг хүргүүлж төлбөрийг цаг хугацаанд нь бүрэн барагдуулан ажилласан.

Дотоодын агаарын тээвэрлэгч байгууллагуудаас тайлант хугацаанд өр үүсгэхгүй, мөн урьд онуудын өр төлбөрийг бууруулж ажиллахаар гэрээ байгуулан ажилласан боловч тайлант хугацааны үйл ажиллагааны



орлого нь тухайн оны үйл ажиллагааны зардалд зарцуулагдаж өр төлбөрийг бууруулахад хүндрэлтэй байгаа талаар удаа дараа хүсэлт ирүүлээд байна.

Дотоодын агаарын тээвэрлэгчдийн авлага 2017 онд 14.8 тэрбум төгрөг, 2018 онд 14.5 тэрбум төгрөг, 2019 онд 16.5 тэрбум төгрөг байсан бол 2020 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар 16.0 тэрбум төгрөгт хүрч авлага 0.5 тэрбум төгрөг буюу 3.0 хувиар буурсан. Тайлант онд Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн “Агаарын тээврийн салбарт авах зарим арга хэмжээний тухай” 137 дугаар тогтоолын 2 дахь заалтад “Олон улс болон орон нутгийн чиглэлд хуваарьт нислэг гүйцэтгэдэг аж ахуйн нэгжийн Иргэний нисэхийн ерөнхий газарт төлөх агаарын навигацийн үйлчилгээний хураамжийн хуримтлагдсан өглөгийг чөлөөлөх” гэж заасны дагуу “МИАТ” ТӨХК-тай холбоотой 2,1 тэрбум төгрөгийн авлагыг бууруулсан боловч авлагын бууралт 3 хувь байгаа нь Дэлхий нийтэд COVID-19 халдварт вирус тархаж, онц нөхцөл байдал үүссэний улмаас агаарын тээврийн салбарын үйл ажиллагаа зогсонги байдалд орж санхүүгийн хүндрэл үүссэнтэй холбоотой. Өнгөрөлтийн нислэг үйлдэж буй гадаадын 100 гаруй агаарын тээвэрлэгчдээс 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 175.1 тэрбум төгрөг нэхэмжилсэн нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 120.0 тэрбум төгрөг буюу 41 хувиар буурсан үзүүлэлт байна.

Гадаадын агаарын тээвэрлэгчдээс авах дансны авлагын судалгааг гаргаж авлагыг бууруулах талаар тухайн улс дах буюу Москва, Итали улс дах Монгол улсын элчин сайдын яамдаар дамжуулан албан бичгийг хүргүүлж ажилласнаас ОХУ-ын Хууль зүйн яамнаас тус улсын агаарын тээврийн Аэрофракт компаний дампуурлын талаарх мэдээлэл мөн Итали улсын агаарын тээврийн Алиталиа компанитай холбоотой асуудал тус улсын шүүхээр 2020 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр хэлэцэгдэх болсон ба одоогоор шүүхийн шийдвэр ирээгүй гэх мэдээллийг тус тус ирүүлээд байна.

БНХАУ-ын дампуурсан “Jade Cargo” агаарын тээврийн компанийн шүүхийн эцсийн шийдвэрийг ирүүлсний дагуу 80430 ам.долларыг дансаас хасах талаарх саналыг даргын зөвлөлөөр хэлэлцүүлэх талаар бэлтгэж байна.

#### *Шилэн дансны хуулийн хэрэгжилт*

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2020 оны сар, улирлын төсөв, гүйцэтгэл, бусад мэдээллийг хуульд заасан хугацаанд нь шилэн дансанд байршуулан ажиллаж байна. Шилэн дансны тухай хуулийг 2015 оноос хэрэгжүүлэн байгууллагын цахим хуудсыг шилэн данстай холбон нийт 21 нэгжийн шилэн дансны цахим системд нэвтрэх эрхийг олгон ажилласан. 5 сая төгрөгөөс дээш үнэ бүхий мөнгөн гүйлгээнд 2020 оны 3 дугаар улирлын байдлаар 2310 ширхэг баримтаар 310.5 тэрбум төгрөгийг тайлагнасан.

#### *Хөрөнгө оруулалтын талаар:*

Худалдан авах ажиллагааны тасаг нь 2020 онд нийт 147 төсөл арга хэмжээг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч хэмнэлтийн горимд шилжүүлэх 24 төсөл арга хэмжээ, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын зөвлөлийн 2020 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн шийдвэрээр “Ковид-19” цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан 26 төсөл арга хэмжээ хойшлуулахаар шийдвэрлэж, нийт 97 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулж ажилласан байна.

Үүнд:

- Бүрэн хэрэгжсэн - 48 төсөл арга хэмжээ
- Комисс томилогдож ажил хүлээн авч байгаа - 5 төсөл, арга хэмжээ
- Гэрээ байгуулагдаж, хэрэгжиж буй – 24 төсөл, арга хэмжээ
- Тендер нээсэн, гэрээ байгуулах эрх олгогдсон- 4 төсөл, арга хэмжээ
- Тендер нээхээр хүлээж буй-3 төсөл, арга хэмжээ
- Шууд худалдан авалт хийх-1 төсөл, арга хэмжээ
- Гэрээ сунгах-1 төсөл, арга хэмжээ
- Шууд гэрээ байгуулах зөвлөмж гарсан-1 төсөл, арга хэмжээ
- Тендер нээсэн, үнэлж буй – 7 төсөл, арга хэмжээ
- Амжилтгүй болсон- 3 төсөл, арга хэмжээ

Нийт Гүйцэтгэл 83,4%

#### ***Шилэн данс, хэмнэлт, ил тод байдал, гомдол хянан шийдвэрлэсэн байдал:***

- Худалдан авах ажиллагааны тасаг нь 97 төсөл, арга хэмжээг давхардсан тоогоор 196 удаагийн тендер шалгаруулалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) -ээр зохион байгуулан ажилласан байна.
- Үнэлгээний хороонд ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлгийг давхардсан тоогоор 1000 орчим гишүүн

Үнэлгээний хорооны ашиг сонирхлын мэдүүлгийг давхардсан тоогоор 1300 гаруй гишүүн тус тус гаргасан байна.

#### **Найм. Хяналт-шинжилгээ, дотоод аудитын чиглэлээр:**

##### *Хяналт-шинжилгээний талаар:*

Хэрэгжилтийг тогтмол гаргаж, Зам, тээврийн хөгжлийн яаманд мэдээлж байх бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, дээд газрын тушаал шийдвэр, төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын талаарх мэдээллийг



нэгжүүдээс гаргуулан авч, нэгтгэж, гүйцэтгэлд хяналт-шинжилгээ хийж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа. Үүнд:

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын эдийн засаг нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн байдлыг улирал бүр гаргаж, байгууллагын удирдлагад танилцуулан, ЗТХЯ-нд тогтоосон хугацаанд хүргүүлж байна. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 22 арга хэмжээний 2020 онд хийх ажил энэ оны 92.5%-тай, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан 3 арга хэмжээ үнэлэх боломжгүй байна.

“Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-ыг хэрэгжилтийг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 2 дугаар хавсралтын “Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнах маяг”-ын дагуу гаргаж, суурь түвшин, шалгуур үзүүлэлтийг арга хэмжээ бүрээр нөхөж гаргаж, хяналт-шинжилгээ хийж, 2020 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн 01/ 262 тоот албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн. Мөн хяналт-шинжилгээний тайланг удирдлагуудад танилцуулж, нэгжүүдэд хүргүүлсэн. Бодлогын хэрэгжилт 2019 оны жилийн эцсийн байдлаар 73.4%-тай байна. Бодлогыг хэрэгжүүлэх хугацаа энэ онд дуусгавар болж байгаатай холбогдуулан бодлогын зорилго, зорилт, арга хэмжээний хэрэгжилт гэсэн 3 үзүүлэлтээр үнэлэхээр бэлтгэж, шалгуур үзүүлэлтийг тогтоож байна.

ИНЕГ-ын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг энэ оны эхний хагас жилийн байдлаар гаргаж, Зам, тээврийн хөгжлийн яамаар үнэлүүлсэн. Одоо биелэлтийг жилийн эцсийн байдлаар гаргаж, хяналт-шинжилгээ хийж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1 зарлигийн 2 заалт, Засгийн газрын 9 тогтоолын 10 заалт, Засгийн газрын хуралдааны 8 тэмдэглэлийн 22 заалт, нийт 18 шийдвэрийн 34 заалтыг хяналтад авч, хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч байна. 2020 оны 3 дугаар улирлын байдлаар 83.1%-ийн хэрэгжилттэй байсан. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2014 оны 1 тушаалын 1 заалт, 2015 оны 2 тушаалын 2 заалт, 2016 оны 8 тушаалын 9 заалт, 2017 оны 6 тушаалын 10 заалт, 2018 оны 7 тушаалын 24 заалт, 2019 оны 20 тушаалын 28 заалт, 2020 оны 21 тушаалын 67 заалтыг хяналтад авч, хэрэгжүүлж байна. 2020 оны 3 дугаар улиралд сайдын 6 тушаалын 10 заалтыг нэмж хяналтад авсан. Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгавар энэ оны 3 дугаар улирлын байдлаар 88.8%-ийн хэрэгжилттэй байсан. Улирал бүр хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж тайлан мэдээг тогтоосон хугацаанд Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлж байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын үйл ажиллагааны чиглэлээрх тушаалын хэрэгжилтэд улирал бүр хяналт-шинжилгээ хийж, тайланг нэгжүүдэд хүргүүлж, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.

Сайдын зөвлөлийн хуралдааны 2017 оны 1 хуралдааны 7 шийдвэр, 2018 оны 2 хуралдааны 5 шийдвэр, 2019 оны 6 хуралдааны 6 шийдвэр, 2020 оны 4 хуралдааны 10 шийдвэр, нийт 13 хуралдааны 31 үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч байна. Сайдын зөвлөлийн хуралдаанаас өгсөн үүрэг даалгавар 2020 оны 3 дугаар улирлын байдлаар 70.6%-ийн хэрэгжилттэй. Улирал бүр хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж тайлан мэдээг тогтоосон хугацаанд Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлж ажилласан.

ИНЕГ-ын даргын тус байгууллагын нэгжийн дарга нартай 2019 онд байгуулсан үр дүнгийн гэрээг дүгнэж, ИНЕГ-ын даргын зөвлөлийн 2020 оны 1 дүгээр хурлаар хэлэлцүүлсэн.

ИНЕГ-ын даргын тус байгууллагын нэгжүүдийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэсэн.

Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.

#### *Дотоод аудитын талаар:*

Дотоод аудит, хяналт шалгалт хийх хуваарийн дагуу 30 алба, нэгжид төлөвлөгөөт шалгалтыг 38 удаа, төлөвлөгөөт бус шалгалтыг 9 удаа, нийт 47 удаа дотоод аудит, хяналт шалгалтыг хийсэн. Мөн 1 иргэнээс ирүүлсэн өргөдлийн дагуу шалгалт хийж хариуг хүргүүлсэн. Энэхүү дотоод аудит, хяналт шалгалтаар нийт 146.6 сая төгрөг, 21.8 мянган ам.долларын зөрчил илрүүлж, зөрчлийг засч залруулах 305 зөвлөмж өгч, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Зөвлөмжийн хэрэгжилт 77 хувьтай байна. Цалин хөлс, түүнтэй адилтгах бусад мөнгөн тооцоо, хоолны үнийн хөнгөлөлтийн тооцоогоор илэрсэн зөрчлийг арилгах хугацаатай үүрэг өгч, дутуу олгосон цалин хөлсийг нөхөж олгож, илүү олгосныг төлүүлсэн.

ИНЕГ, түүний харьяа нэгжүүдийн шилэн дансны цахим хуудсыг сар бүр хянаж, зөрүүтэй мэдээллийг тухай бүрд нь залруулах арга хэмжээ авч байна. Мөн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, хуулийн хугацаанд мэдээ, тайланг үнэн зөв, иж бүрэн байршуулж хэвшүүлэх, хуулийг хангалтгүй хэрэгжүүлсэн албан тушаалтанд хариуцлага тооцох, хууль, журмын хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгч зөрчлийг арилгах, засч залруулах зорилгоор улирал бүр аудит хийж хэвшсэн. Мэдээллийн нэгдсэн тайланг улирал бүрийн дараа сарын 15-ны дотор ЗТХЯ-нд хүргүүлж байна.

2020 онд Чингис хаан ОУНБ, НЖБА, ОХЗЛ, НМҮА зэрэг нэгжүүдэд эрсдэлийн үнэлгээ хийсэн. Нэгж тус бүрийн хувьд эрсдэлийн төрөл бүр дээр тохиолдох магадлал ба нөлөөллийг тооцсон. Эрсдэлүүдийг тогтоохдоо өмнө хийсэн аудитаар илэрсэн эрсдэлүүдийг их, дунд, бага түвшингээр ангилж, аудит хийгдээгүй нэгж, үйл ажиллагааг ерөнхий байдлаар оруулсан. Хийгдсэн аудитын тайланг үндэслэн эрсдэлийн санг хөтлөн, эрсдэлийг түвшингээр ангилан тухай бүр өөрчлөлт оруулж байна.

#### ДҮГНЭЛТ:

Тус газар нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд



хөгжүүлэх үндсэн чиглэл, Төрөөс иргэний нисэхийн талаар баримтлах бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх, салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн баримт бичгийг шинэчлэн боловсруулж, хууль тогтоомжийг Олон улсын иргэний нисэхийн байгууллагын эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэх, салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллалаа.

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР